# СҮХБААТАР АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2019 оны 12 сарын 04 өдөр Дугаар 10/07 Баруун-Урт сум

“Аймгийн хөгжлийн зорилт 2020-2028”
хөгжлийн бодлогын баримт бичиг
батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-ын “а”, “з”, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 14.1 дэх хэсгүүдийг тус тус үндэслэн Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит 10 дугаар Хурлаас ТОГТООХ нь:

1.“Аймгийн хөгжлийн зорилт 2020-2028” бодлогын баримт бичгийг хавсралтаар баталсугай.

2.Хөгжлийн бодлогын зорилтын баримт бичгийн хэрэгжилтийг хангах арга хэмжээг жил бүрийн улс, орон нутгийн төсөв, үндсэн чиглэлд тусган хэрэгжүүлж биелэлт, үр дүнг тооцон ажиллахыг аймгийн Засаг дарга /Ж.Эрдэнэбаатар/-д даалгасугай.

ДАРГА Б.МӨНХБАТ

2

# СҮХБААТАР АЙМГИЙН ХӨГЖЛИЙН ХЭТИЙН ЗОРИЛТ

2020-2028 он

2019 ОН

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
....2019.....оны.....12..дугаар сарын.....04..ний
өдрийн..10/07..дугаар тогтоолын хавсралт

# СҮХБААТАР АЙМГИЙН ХӨГЖЛИЙН ХЭТИЙН ЗОРИЛТ 2020-2028

## НЭГ. АЛСЫН ХАРАА, ЭРХЭМ ЗОРИЛГО, ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ

Уриа: Хөгжлийн төлөө хамтдаа

Алсын харaa: Азийн тээвэр логистикийн нэгдсэн платформд суурилсан боловсруулах аж үйлдвэрлэлийн кластерийн сүлжээнд нэгдэх.

Эрхэм зорилго: Мэдлэгт суурилсан хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, тээвэр логистикийн хөгжлийн тулгуур төв болох.

Хэтийн зорилтыг дараах 4 тэргүүлэх чиглэлийн хүрээнд тодорхойлов.

### ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 1: НИЙГМИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ

Хүн төвтэй хөгжлийн бодлогыг баримтлан иргэн бүрийг эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг хангана.

### ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 2: ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ

Шинжлэх ухаан, технологи, инноваци дэд бүтцэд тулгуурлан, өрсөлдөх чадвар бүхий хөдөө аж ахуй, үйлдвэрлэл, аялал жуулчлалыг хослуулан хөгжүүлэх замаар бие даасан эдийн засгийн хөгжлийг хангана.

### ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 3: БАЙГАЛЬ ОРЧНЫ ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ

Бүх нийтийн оролцоонд тулгуурлан экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалж, байгалийн нөөцийг урт хугацаанд үр өгөөжтэй, зүй зохистой ашиглаж, хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ авч байгаль орчны тогтвортой хөгжлийг хангана.

### ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 4: ЗАСАГЛАЛЫН ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ

Үр нөлөөтэй, хүртээмжтэй, хариуцлагатай, тэгш оролцоо бүхий нээлттэй, ардчилсан засаглалыг төлөвшүүлж, иргэдийн амар тайван, аюулгүй амьдрах орчныг бүрдүүлнэ.

Аймгийн хөгжлийн хэтийн зорилтыг 2 үндсэн үе шаттай хэрэгжүүлнэ.

- 1 дүгээр үе шат: 2020-2024 он
- 2 дугаар үе шат: 2025-2028 он

# ХОЁР. СҮХБААТАР АЙМГИЙН ХӨГЖЛИЙН ХЭТИЙН ЗОРИЛТЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ

## 2.1 НИЙГМИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ

Хүн төвтэй хөгжлийн бодлогыг баримтлан иргэн бүрийг эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг хангана.

Тэргүүлэх чиглэл 1 дараах зорилго, зорилтуудыг дэвшүүлж байна. Үүнд:

| | |
|---|---|
| ***Зорилго нэг*** | ***Хүн амын амьжиргааны түвшинг дээшлүүлж, амьдралын чанарыг сайжруулах*** |
| Зорилт 1.1 | Хүн бүрд нийгмийн суурь чанартай үйлчилгээг хүртээмжтэй хүргэж, амьдралын чанарыг сайжруулах |
| Зорилт 1.2 | Зохистой хөдөлмөрийн талаар ажил олгогч бүрд зөв хандлагыг төлөвшүүлж, хөдөлмөр эрхлэлтийн оновчтой бодлогыг хэрэгжүүлж, жижиг, дунд бизнесийг дэмжих замаар иргэн бүрийг ажилтай, орлоготой болгох |
| Зорилт 1.3 | Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйлчилгээний бүх сүлжээнд эрүүл, аюулгүй байдлын стандартыг хэвшүүлж, хяналтын тогтолцоог сайжруулж, хүн амыг шим тэжээллэг, баталгаат хүнсээр хүртээмжтэй, тогтвортой хангах |
| ***Зорилго хоёр*** | ***Эрүүл, чийрэг иргэнийг төлөвшүүлж, эрүүл мэндийн чанартай тусламж үйлчилгээний хүртээмжийг дээшлүүлж, хүн амын дундаж наслалтыг уртасгах*** |
| Зорилт 2.1. | Нийгмийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, иргэдэд эрүүл амьдралын дадлыг хэвшүүлж, урьдчилан сэргийлэх тогтолцоог бэхжүүлэх замаар хүн амын дундаж наслалтыг уртасгах |
| Зорилт 2.2. | Халдварт болон халдварт бус өвчний эрт илрүүлэлт, эрүүл мэндийн оношилгоо, эмчилгээ, хяналт, тандалтын чанар хүртээмжийг сайжруулах замаар нас баралтыг бууруулах |
| Зорилт 2.3. | Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хүн бүрд хүргэх |
| Зорилт 2.4. | Хүн амын эрэлт хэрэгцээнд нийцсэн, стандартын шаардлага хангасан, хариуцлагатай, хүртээмжтэй, үйлчлүүлэгч төвтэй эмнэлгийн тусламж үйлчилгээний тогтолцоог хөгжүүлэх |
| ***Зорилго гурав*** | ***Хүн бүрд боловсрол, соёл, шинжлэх ухааны чанартай үйлчилгээг тэгш, хүртээмжтэй хүргэх, насан туршийн боловсролын тогтолцоог хөгжүүлэх*** |
| Зорилт 3.1. | Хүүхэд бүрийг стандартын шаардлагад нийцсэн сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын үйлчилгээнд хамруулж, монгол хэл сэтгэлгээний үндсийг эзэмшүүлэх |
| Зорилт 3.2. | Хөгжлийн тэргүүлэх чиглэл, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлт, шинжлэх ухаан технологийн дэвшилтэй уялдуулан мэргэжлийн боловсрол, сургалтыг хөгжүүлэх, хувийн хэвшилтэй хамтран төгсөгчдийг ажлын байраар хангах |
| Зорилт 3.3. | Мэдээллийн технологийн платформд суурилсан насан туршийн боловсролын тогтолцоог бүрдүүлэх |
| Зорилт 3.4. | Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарын хүний нөөцийн тогтвортой бодлогыг хэрэгжүүлж, ажилтны нийгмийн |

| | |
|---|---|
| | баталгаа хангагдсан хөгжлийг дэмжих тогтолцоог бүрдүүлэх |
| Зорилт 3.5. | Бүх нийтийн биеийн тамираар хичээллэх, амралт чөлөөт цагаа өнгөрүүлэх орчин нөхцөлийг сайжруулж, дэд бүтцийн хүртээмжийг нэмэгдүүлж, үндэсний болон олон улсын спортыг хөгжүүлэх |
| Зорилт 3.6. | Аймгийн брэнд бүхий соёлын биет бус өв, бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх, соён гэгээрүүлэх ажлыг шинэ шатанд гаргах |
| ***Зорилго дөрөв*** | ***Хүн бүрийн эрхийг хүндэлж, тэдний онцлог хэрэгцээнд нийцүүлэн хөгжих, суралцах, хөдөлмөрлөх таатай орчин нөхцөлийг бүрдүүлэх*** |
| Зорилт 4.1. | Гэр бүл, хүүхдэд ээлтэй хөгжил, хамгааллын бодлогыг хэрэгжүүлж, хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлэх замаар хүн амын өсөлт, хөгжлийг дэмжих |
| Зорилт 4.2. | Залуучуудын гэр бүл төлөвлөлтийн талаарх мэдлэгийг дээшлүүлж, гэр бүлийн тогтвортой байдлыг хангах, залуучуудыг түүх, соёл, зан заншил, уламжлалаа мэддэг, эх оронч үзэлтэй, бие даан амьдрах чадвартай, хариуцлагатай иргэн болгон төлөвшүүлэхэд нийгмийн үйлчилгээг чиглүүлж, залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих |
| Зорилт 4.3. | Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан дэд бүтцийг сайжруулж, тэдэнд нийгмийн хамгаалал, халамжийн үйлчилгээг жигд тэгш хүргэх, хөгжилд хувь нэмрээ оруулан бие даан амьдрах таатай орчинг бүрдүүлэх |
| Зорилт 4.4. | Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцаан дахь жендерийн эрх тэгш байдлыг хангаж, нийгмийн амьдралд оролцох оролцоог дээшлүүлж, шийдвэр гаргах бүх түвшинд эмэгтэйчүүдийн эзлэх хувь хэмжээг нэмэгдүүлэх |

## 2.2. ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ

Шинжлэх ухаан, технологи, инновац, дэд бүтцэд тулгуурлан, өрсөлдөх чадвар бүхий хөдөө аж ахуй, үйлдвэрлэл, аялал жуулчлалыг хослуулан хөгжүүлэх замаар бие даасан эдийн засгийн хөгжлийг хангана.

Тэргүүлэх чиглэл 2 дараах зорилго, зорилтуудыг дэвшүүлж байна. Үүнд:

| ***Зорилго тав*** | ***Эдийн засгийн өрсөлдөх чадварыг дээшлүүлж, бие даасан байдлыг хангах*** |
|---|---|
| Зорилт 5.1. | Эдийн засгийг төрөлжүүлэн хөгжүүлж, түүний өсөлтийг тогтворжуулан улсын төсвөөс хамааралтай байдлыг бууруулах |
| Зорилт 5.2. | Бизнес эрхлэх таатай орчин, дэд бүтцийг бүрдүүлж, нэмүү өртгийн сүлжээ бүхий технологи, инновацын ололтод суурилсан эдийн засгийн үр ашигтай орон нутгийн эко бизнес, үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээг хөгжүүлэх |
| Зорилт 5.3. | Унаган байгаль, түүх, соёл, нүүдэлчин ахуйг түшиглэсэн хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд суурилсан эко бизнес, хил орчмын аялал жуулчлалыг эрчимтэй хөгжүүлэх |
| Зорилт 5.4. | Технологи, инновацад суурилсан өрсөлдөх чадвартай, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн загвар аймаг болох |
| Зорилт 5.5. | Байгалийн нөөц, ашигт малтмалын баялагт суурилсан ил тод, |

| | |
|---|---|
| | хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх замаар орон нутгийн хөгжлийг дэмжиж бүсийн эдийн засгийн тулгуур төв болох |
| ***Зорилго зургаа*** | ***"Нэг бүс нэг зам" санаачилгыг дэмжин Ази – Европыг холбосон эдийн засгийн хөгжлийн коридорыг байгуулан, бүс нутгийн интеграцид идэвхитэй оролцох*** |
| Зорилт 6.1. | Шинэ технологи, сэргээгдэх эрчим хүчийг нэвтрүүлж хэрэглээг дэмжих, тогтвортой үйлдвэрлэлийг хөгжүүлэх |
| Зорилт 6.2. | Хот байгуулалт, инженерийн дэд бүтцийг сайжруулан, иргэдийн эрүүл аюулгүй тохилог орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх |
| Зорилт 6.3. | Дэлхийн зах зээлд хамгийн бага зардлаар хүрэх тээвэр, зуучлал, эдийн засгийн логистикийг хөгжүүлэх |
| Зорилт 6.4. | Мэдээлэл, холбооны технологийн хүртээмж, ухаалаг хэрэглээг нэмэгдүүлэх |
| Зорилт 6.5. | Орон нутгийн чадавхид тулгуурлан инновацыг нутагшуулан, хөгжүүлэх |

## 2.3. БАЙГАЛЬ ОРЧНЫ ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ

Бүх нийтийн оролцоонд тулгуурлан экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалж, байгалийн нөөцийг урт хугацаанд үр өгөөжтэй, зүй зохистой ашиглаж, хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ авч байгаль орчны тогтвортой хөгжлийг хангана.

Тэргүүлэх чиглэл 3 дараах зорилго, зорилтуудыг дэвшүүлж байна. Үүнд:

| | |
|---|---|
| ***Зорилго долоо*** | ***Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг багасгах, цаг агаарын аюулт үзэгдэл, байгалийн гамшигийг даван туулах, тэдгээрт дасан зохицох чадавхийг бэхжүүлэх*** |
| Зорилт 7.1. | Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох бодлого хэрэгжүүлж, ус, бэлчээрийн менежментийг сайжруулж, зүй зохистой ашиглах замаар уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг үр дагавар, эрсдэлийг бууруулах |
| Зорилт 7.2. | Орон нутгийн гамшгийн нөхцөл байдал, эрсдэлийн үнэлгээг бүх түвшинд хийж, гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлж, иргэний нийгмийн байгууллага, иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх |
| ***Зорилго найм*** | ***Амьтан, ургамал, тэдний удмын санг хамгаалах, зүй зохистой ашиглах*** |
| Зорилт 8.1. | Нутгийн иргэдэд түшиглэсэн байгалийн нөөцийн менежментийг төлөвшүүлж, менежментийн үр ашигтай байдлыг сайжруулж байгалийн нөөц баялгийг хамгаалах, нөхөн сэргээх, зүй зохистой ашиглах бодлогыг хэрэгжүүлэх |
| Зорилт 8.2. | Биологийн олон янз байдлын удмын санг хамгаалах, тархац нутаг, амьдрах орчинг тэтгэх замаар хомсдолоос сэргийлэх |
| ***Зорилго ес*** | ***Байгаль орчны бохирдол доройтлыг бууруулж, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалах*** |
| Зорилт 9.1. | Агаар, ус, хөрсний бохирдол, доройтлын шалтгаан, үр дагаврыг судлан тогтоож, байгальд ээлтэй, үр ашигтай цэвэр технологи нэвтрүүлж, орчны бохирдлыг бууруулах |
| Зорилт 9.2. | Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь бууруулах, ангилах, дахин |

| | |
|---|---|
| | ашиглах, дахин боловсруулах менежментийг хэрэгжүүлж, эдийн засгийн эргэлтэд оруулах, хариуцлагатай хэрэглээг дэмжих |

## 2.4. ЗАСАГЛАЛЫН ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ

Үр нөлөөтэй, хүртээмжтэй, хариуцлагатай, тэгш оролцоо бүхий нээлттэй, ардчилсан засаглалыг төлөвшүүлж, иргэдийн амар тайван, аюулгүй амьдрах орчинг бүрдүүлнэ.

Тэргүүлэх чиглэл 4 дараах зорилго, зорилтуудыг дэвшүүлж байна. Үүнд:

| **Зорилго арав** | **Засаглалын бүх шатанд хариуцлага, ил тод байдлыг хангасан, оролцоо бүхий чадварлаг институцийг бүрдүүлэх** |
|---|---|
| Зорилт 10.1. | Бүх нийтийн эрхзүйн боловсролыг дээшлүүлж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийгмийн дэг журмыг хангах замаар амар тайван амьдрах нөхцөлийг бий болгох |
| Зорилт 10.2. | Нутгийн өөрөө удирдах ёсны болон захиргааны байгууллагаас боловсруулж байгаа бодлого, түүний хэрэгжилтэд салбар хоорондын уялдаа холбоо хамтын ажиллагааг хангаж, хяналт үнэлгээний үр дүнг сайжруулах |
| Зорилт 10.3. | Төрийн албаны чадавхи, бодлогын залгамж чанарыг сайжруулж, манлайллыг бэхжүүлж, мэргэшсэн, чадварлаг, тогтвортой төрийн албыг төлөвшүүлж, төрийн үйлчилгээг иргэдэд чанартай, шуурхай, тэгш хүртээмжтэй хүргэх |
| Зорилт 10.4. | Шийдвэр гаргах үйл явцыг ил, тод шуурхай, хүртээмжтэй болгож, иргэд, олон нийтийн оролцоог идэвхижүүлж, нутгийн удирдлагын түвшинд төр, хувийн хэвшил, эрдэм шинжилгээ, иргэний нийгмийн болон хил залгаа, хамтын ажиллагаатай хотуудын түншлэлийг дэмжин хөгжүүлэх |

## ГУРАВ. СҮХБААТАР АЙМГИЙН ХӨГЖЛИЙН ХЭТИЙН ЗОРИЛТЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ ГОЛ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Зорилт 1.1: Хүн бүрд нийгмийн суурь чанартай үйлчилгээг хүртээмжтэй хүргэж, амьдралын чанарыг сайжруулах

**Хэрэгжүүлэх гол үйл ажиллагаа**

1.1.1.Эрүүл мэнд, боловсрол, нийгмийн суурь үйлчилгээ, барилга, дэд бүтэц, хөдөлмөр эрхлэлт зэрэг салбар дундын асуудлыг уялдуулсан ядуурлыг бууруулах дундаж түвшинд хүргэх дэд хөтөлбөрийг иргэдийн хэрэгцээ чадавхид тулгуурлан боловсруулж хэрэгжүүлэх, энэ чиглэлээр хэрэгжиж буй сангуудын үйл ажиллагааг уялдуулан зохион байгуулалттай хэрэгжүүлэх, санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлэх

1.1.2.Хүн амын зорилтот бүлгийн хэрэгцээнд тохирсон урьдчилан сэргийлэх, хамгаалах, хөгжүүлэх, зуучлах нийгмийн хамгаалал, халамжийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах

1.1.3.Хүүхэд, өсвөр үе, залуучуудад үндэсний уламжлал, хэл соёл, зан заншил, эх оронч, хөдөлмөрч үзэл төлөвшүүлэх, хүмүүжүүлэх асуудлыг гэр бүл, боловсролын бодлоготой уялдуулж хэрэгжүүлэх

1.1.4.Малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, ажил хөдөлмөр эрхэлдэггүй иргэдийн нийгмийн даатгалд хамрагдах ухамсрыг төлөвшүүлэхэд чиглэсэн нөлөөллийн ажлуудыг үе шаттай зохион байгуулж ажилтны эрх ашиг, нийгмийн баталгааг хангах үндсэн үүргээ хэрэгжүүлэх нийгмийн даатгалын шимтгэлийг хуульд нийцүүлэн төлөх, эрүүл мэндийн болон нийгмийн даатгалд бүрэн хамруулах талаар иргэд, ажил олгогчдод чиглэсэн үйл ажиллагааг хамтран зохион байгуулах

1.1.5.Иргэдийг орон сууцжуулах, дулааны хэмнэлттэй, тохилог сууцтай болох бодлогыг дэмжин хөгжүүлэх, түрээсийн орон сууц хөтөлбөр хэрэгжүүлэх

1.1.6.Усны хатуулаг ихтэй болон цэвэршүүлэх шаардлагатай ундны ус бүхий сумдын төвийн гүний өрмийн худагт ус цэвэршүүлэх төхөөрөмж суурилуулах, гэр хорооллын худгуудын энгийн хамгаалалтын бүсийн дэглэмийг мөрдүүлэх, зэргээр баталгаат усан хангамжийн асуудлыг цогцоор шийдвэрлэх

1.1.7.Угаалга, химицэвэрлэгээззэрэг хувь хүнд чиглэсэнүйлчилгээнүүдийг хөгжүүлж, сумдад ахуйн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх

1.1.8.Өрхийн хэрэглээнээс гадна өрхийн аж ахуй эрхлэхэд хүрэлцэхүйц байхаар алслагдсан бүс нутагт амьдарч буй иргэд болон малчдад сэргээгдэх эрчим хүчний шинэ технологи бүхий эх үүсвэртэй болоход дэмжлэг үзүүлэх, мэдээллээр хангах

1.1.9.Сумдад уламжлалт болон салхи, нарны халаалтын систем хосолсон бага оврын эрчим хүчний эх үүсвэр, дулааны түгээх сүлжээ барих ажлыг санаачлан хэрэгжүүлэх

**Зорилт 1.2**:Зохистой хөдөлмөрийн талаар ажил олгогч бүрд зөв хандлагыг төлөвшүүлж, хөдөлмөр эрхлэлтийн оновчтой бодлогыг хэрэгжүүлж, жижиг, дунд бизнесийг дэмжих замаар иргэн бүрийг ажилтай, орлоготой болгох

**Хэрэгжүүлэх гол үйл ажиллагаа**

1.2.1.Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн 20-30 жилийн хэтийн төлөвлөлт хийж, мэргэжлийн боловсролын сургалттай уялдуулах

1.2.2.Ажилгүй, бага орлоготой иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж малжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлэх, тариалангийн зохих хэмжээний талбайг тодорхой хугацаагаар эзэмшүүлж, гоёлын болон бусад жимс, жимсгэнийн төрөл бүрийн суулгацын үйлдвэрлэлийг дэмжиж иргэдийн орлогыг нэмэгдүүлэх

1.2.3.Жижиг, дунд бизнес эрхлэгчид болон эрчимжсэн аж ахуй эрхлэлтийг дэмжиж, хүний нөөцийг сургаж, дадлагажуулж бэлтгэх, эдийн засгийн илүү үр ашигтай байх загварыг хөгжүүлэх;

1.2.4.Жижиг дунд үйлдвэр, гар урлал эрхлэгчдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, бэлэг дурсгалын зүйлсийг борлуулахад дэмжлэг үзүүлэх

1.2.5.Албан бус хэлбэрээс албан хэлбэрт шилжиж буй ажлын байрыг дэмжих

1.2.6.Экспортын баримжаатай үйлдвэрлэлийг дэмжиж, төр-хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байнгын ажлын байрыг нэмэгдүүлж, өрсөлдөх чадвартай мэргэжилтэн бэлтгэх

1.2.7.Технологи нутагшуулах хугарлын цэг багатай жижиг, дунд үйлдвэрлэлийг бүх талаар дэмжих, өрхийн үйлдвэрлэлээс илүү дундын ашиг сонирхол, өртгийн болон кластерын сүлжээнд нэгдэх сонирхлыг өдөөх

1.2.8.Аймагт нэн шаардлагатай байгаа мэргэжилтний судалгааг гаргаж, тухайн мэргэжлийг эзэмшээд нийслэл болон өөр аймгуудад амьдарч, сурч байгаа иргэдээ татах үйл ажиллагааг зохион байгуулж, бэлтгэгдсэн хүний нөөцийг бүрдүүлэх чиглэлд үйл ажиллагаагаа эрчимжүүлэх

Зорилт 1.3:Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйлчилгээний бүх сүлжээнд эрүүл, аюулгүй байдлын стандартыг хэвшүүлж, хяналтын тогтолцоог сайжруулж, хүн амыг шим тэжээллэг, баталгаат хүнсээр хүртээмжтэй, тогтвортой хангах

**Хэрэгжүүлэх гол үйл ажиллагаа**

1.3.1.Хүнсний болон хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай, Органик хүнсний тухай хуулиудын хэрэгжилтийг хангаж, хоол тэжээл, хүнсний хангамж, илчлэг чанар, аюулгүй байдлын цогц бүртгэл мэдээллийн нэгдсэн сан үүсгэж, хяналтад авч ашиглах;

1.3.2.Хүнс боловсруулах үйлдвэрт эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн зохистой дадлыг хэвшүүлэх, холбогдох зааврыг боловсруулж батлуулах, олон улсын болон үндэсний эрүүл ахуйн чанарын стандартыг нэвтрүүлэх;

1.3.3.Органик хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаа экспортыг дэмжих;

1.3.4.Хүнсний хэрэглээ, зөв хооллолт, хүнсний аюулгүй байдлын талаарх хэрэглэгчдийн мэдлэг ойлголтыг дээшлүүлэх арга хэмжээ авах;

1.3.5.Нийтийн гал тогоо бүхий байгууллагуудын хоол хүнсний хангалтад эрүүл ахуйн стандарт, шаардлагыг тогтмол мөрдүүлж хэвшүүлэх

1.3.6.Хүнсний сүлжээний бүх үе шатанд хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах; хадгалах, хамгаалах, тээвэрлэх байр, техник, технологийн нөхцөлийг хангах

1.3.7.Хүнсний зориулалтаар бэлтгэх мал, амьтан, таримал ургамлын эрүүл аюулгүй, баталгаат байдлыг хангах;

1.3.8.Хүнсний аюулгүй байдлыг хангах асуудалд төрийн болон төрийн бус байгууллагууд, хувийн хэвшлийн уялдаа холбоо, хамтын ажиллагааг хөгжүүлэх;

1.3.9.Хүнсний болон бусад бараа бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг хангуулах зорилгоор стандартчилал хэмжилзүйн хэлтэс, мэргэжлийн хяналтын газрын лабораторийг шаардлагатай суурин болон зөөврийн тоног төхөөрөмжөөр хангах;

1.3.10.Мал амьтан, ургамлын гаралтай болон хүнсний бус түүхий эдийн ариун цэврийн шаардлага хангасан лабораторитой болох

1.3.11.Үйлдвэрийн аргаар боловсруулсан махны үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх

1.3.12.Стандартын бус ундны сав, баглаа боодлыг хэрэглээнээс хасах, стандартын саваар хангах

**Зорилт 2.1**: Нийгмийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, иргэдэд эрүүл амьдралын дадлыг хэвшүүлж, урьдчилан сэргийлэх тогтолцоог бэхжүүлэх замаар хүн амын дундаж наслалтыг уртасгах

**Хэрэгжүүлэх гол үйл ажиллагаа**

2.1.1.Эрүүл мэндийн зарим тусламж үйлчилгээг иргэн, төрийн байгууллага, хувийн хэвшлийн түншлэл хамтын ажиллагааны оролцоотой зохион байгуулж, салбар дундын хамтын ажиллагааг бэхжүүлэн үр дүнг тооцон ажиллах

2.1.2.Эрүүл, аюулгүй ажлын байрыг дэмжих зорилгоор ажил олгогчдод хандсан цогц арга хэмжээг хэрэгжүүлэх

2.1.2.Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх тусламж үйлчилгээнд сайн дураараа хандах талаарх иргэдийн мэдлэгийг нэмэгдүүлж, хандлагыг өөрчлөх, дадал хэвшил болгох өргөн хэмжээний ухуулга, сурталчилгаа компанит ажлыг байнга зохион байгуулах

2.1.3.Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийг дэмжиж, тэдэнд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмж, чанарыг дээшлүүлэх, эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн өвөрмөц эрэлт хэрэгцээг хангасан мэргэжлийн кабинет байгуулж, мэргэжлийн эмч, мэргэжилтнээр хангах

2.1.4.Архи, тамхины хэрэглээ, хөдөлгөөний хомсдол, буруу хооллолт зэрэг амьдралын буруу хэв маяг, дадал зуршлыг бууруулахад чиглэсэн мэдээлэл сургалт сурталчилгааг оновчтой арга хэлбэрээр, тасралтгүй зохион байгуулж, иргэдэд эрүүл зан үйлийг төлөвшүүлэх

2.1.5.Зам тээврийн, ахуйн ослоос сэргийлэх чиглэлээр мэдээлэл сурталчилгааг эрчимжүүлэх, урьдчилан сэргийлэх ажлыг оновчтой зохион байгуулах

2.1.6.Мал, амьтнаас хүнд дамжих халдварт өвчнөөс сэргийлэх ажлыг салбар дундын оролцоотойгоор болон хил залгаа улс оронтой хамтран зохион байгуулах; Зоонозын төв байгуулах

**Зорилт 2.2**: Халдварт болон халдварт бус өвчний эрт илрүүлэлт, эрүүл мэндийн оношилгоо, эмчилгээ, хяналт, тандалтын чанар хүртээмжийг сайжруулах замаар нас баралтыг бууруулах

**Хэрэгжүүлэх гол үйл ажиллагаа**

2.2.1.Зонхилон тохиолдох халдварт бус өвчин болон орон нутгийн тэргүүлэх өвчлөлд жил бүр судалгаа хийх; мэргэжлийн байгууллагын тусламжтайгаар хариу арга хэмжээг олон нийтийн оролцоотойноор авч хэрэгжүүлэх

2.2.2.“Элэг бүтэн Монгол” хөтөлбөрийн хүрээнд “Элэг бүтэн Сүхбаатар” дэд хөтөлбөрийг боловсруулан, “Элэгний вирусгүй аймаг” аяныг зохион байгуулж, зорилтот бүлгүүдэд элэгний хорт хавдар, В,С вирусийн халдварыг эрт илрүүлж, өвчлөлийг бууруулах, эмчлэх ажлыг зохион байгуулах

2.2.3.Цусны даралт ихсэлт, чихрийн шижин, хөх умайн хүзүүний өмөнгийн эрт илрүүлэлтийг үе шаттайгаар зохион байгуулах

2.2.4.Халдварт өвчний хам шинжийн тандалтыг чанаржуулж, эрт сэрэмжлүүлэг хариу арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлж хэвших

2.2.5.Дархлаажуулалтын хамралт, ялангуяа давтан тунгийн хамралт, дархлаажуулалтад хамрагдалтад тавих хяналтыг чанаржуулах

2.2.6.Хүн амын дундах ДОХ/ХДХВ/БЗДХ-ыг эрт илрүүлэх, оношлох, эмчлэх ажлыг эрчимжүүлж салбар дундын оролцоог нэмэгдүүлэх

2.2.7.Сүрьеэгийн эрт илрүүлэлт, оношилгоо эмчилгээг сайжруулан, тандалт судалгааг зохион байгуулах, сүрьеэгийн халдварыг түргэн хугацаанд оношлох шинэ технологийг нэвтрүүлж, зөөврийн дижитал рентген аппаратаар хангах

2.2.8.Сум дундын эмнэлгүүдийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, хүний нөөцөөр хангаж, мэс засал хийх орчин нөхцөлийг бүрдүүлэн, мэдээллийн технологид суурилсан оношилгооны хэлбэрүүдийг нэвтрүүлэх.

2.2.9.Нэгдсэн эмнэлэгт мэргэжлийн сэтгэл зүйч ажиллуулж, хавдартай болон хүнд өвчтэй иргэнд зөвлөгөө өгч хэвшүүлэх

2.2.10. 59 хүртэлх сартай хүүхдүүдийг өндөр тунтай Д аминдэмээр хангах

**Зорилт 2.3**: Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хүн бүрд хүргэх

**Хэрэгжүүлэх гол үйл ажиллагаа**

2.3.1.Сум, өрх, тосгоны эрүүл мэндийн төвийн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг чадавхижуулах, бэлтгэх; шинэ техник, технологи, дагалдах үйлчилгээг нэвтрүүлэх

2.3.2.Жирэмсэн эмэгтэй бүрийг нэрийн жирэмсний хяналтад хамруулж, эхээс хүүхдэд ХДХВ, гепатит В вирус, тэмбүүгийн халдвар дамжихыг таслан зогсоох арга хэмжээг авч хэрэгжүүлэх

2.3.3.Хүүхдийг товлолт дархлаажуулалтад бүрэн хамруулж, иргэдийн сайн дурын дархлаажуулалтын хамралтыг нэмэгдүүлэх

2.3.4.Аймгийн нэгдсэн эмнэлэг, сум дундын эмнэлэг, сум, өрх, тосгоны эрүүл мэндийн төвүүдэд эх хүүхдийн өвчлөл эндэгдлийг бууруулах, мэргэжил арга зүйн зөвлөгөөгөөр тогтмол хангах, "Эх, хүүхдийн баг"-ийг сумдад ажиллуулах

2.3.5.Гэр бүл төлөвлөлт, жирэмслэхээс сэргийлэх аргад анхан шатны тусламж үзүүлэгчдийг давтан сургах

2.3.6.Нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг өргөжүүлэхэд бодлого боловсруулагч, шийдвэр гаргагчид, хувийн хэвшил, иргэний нийгэм, олон нийтийн оролцоо, түншлэлийг нэмэгдүүлэх сурталчилгаа, нөлөөллийн ажил зохион байгуулах

2.3.7.Нөхөн үржихүйн насны өртөмтгий бүлгийн эмэгтэйчүүдийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулан эмчлэн эрүүлжүүлэх ажлыг зохион байгуулж нөхөн үржихүйн эрүүл мэндэд орон нутгийн төсвөөс зарцуулах санхүүжилтийн хэмжээг үе шаттай нэмэгдүүлэх

2.3.8.Сум өрхийн эрүүл мэндийн төвүүдийг нөхөн үржихүйн эрүүл мэндийн нэн шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслээр, ялангуяа гэр бүл төлөвлөлтийн 3 буюу түүнээс доошгүй хэрэгслээр хангах

2.3.9.Нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм, эмнэлгийн хэрэгслийн хангамж, гэр бүл төлөвлөлтийн тусламж, үйлчилгээнд төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагыг татан оролцуулах

2.3.10.Нийт хүн амд хүүхэд хамгаалал, гэр бүл болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн мэдээлэл, мэдлэг олгох ажлыг төрийн бус байгууллагатай хамтран олон нийтийн мэдээллийн хэрэгслээр хүргэх төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх

2.3.11.Насан туршийн боловсролын төвийн сургалтын хөтөлбөрт нөхөн үржихүйн эрүүл мэндийн асуудлыг тусгаж, багш нарыг нөхөн үржихүйн эрүүл мэндийн сургалтад хамруулах замаар сургууль завсардсан хүүхэд, ажилгүй залуучуудад нөхөн үржихүйн эрүүл мэндийн сургалт, сурталчилгааг зохион байгуулах

2.3.12.ЕБС болон мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн эмч нарыг бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн чиглэлээр сургалтад хамруулж, мэдээлэл, сургалт, сурталчилгааны материал, нөхөн үржихүйн нэн шаардлагатай эм, хэрэгслээр хангах

2.3.13.Оюутан залуучууд, хугацаат цэргийн албан хаагчид, ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдад гэр бүл төлөвлөлтийн талаар мэдээлэл хүргэх, эрүүл мэндийн боловсрол олгох үйл ажиллагааг тогтмол зохион байгуулах

**Зорилт 2.4**: Хүн амын эрэлт хэрэгцээнд нийцсэн, стандартын шаардлага хангасан, хариуцлагатай, хүртээмжтэй, үйлчлүүлэгч төвтэй эмнэлгийн тусламж үйлчилгээний тогтолцоог хөгжүүлэх

**Хэрэгжүүлэх гол үйл ажиллагаа**

2.4.1.Эмч, мэргэжилтнүүдийг дотоод, гадаадын сургалтаар бэлтгэх, давтан сургах, төгсөлтийн дараах сургалтад хамруулах ажлыг бодлогоор дэмжих, төрөлжсөн мэргэжлийн эмч, мэргэжилтний багийг урилгаар ажиллуулж, тэдний туршлагыг түгээн дэлгэрүүлэх

2.4.2.Эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллын хөтөлбөрийг баталж, хэрэгжүүлж, эмчийг тогтвор суурьшилтай ажиллаж амьдрахад нутгийн засаг захиргааны байгууллагаас дэмжлэг үзүүлэх зэрэг арга хэмжээг дэс дараатай хэрэгжүүлэх

2.4.3.Сувилагчийн тоог нэмж нэг сувилагчид ногдох ачааллыг бууруулах замаар өвчтөнд үйлчлэх асаргаа, сувилгааны чанар, хүртээмжийг дээшлүүлэх

2.4.4.Эрүүл мэндийн салбарын хөрөнгө оруулалтын хэмжээг эрс нэмэгдүүлж, бүх шатны эмнэлэг, эрүүл мэндийн төвүүдийг орчин үеийн тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангах, засвар үйлчилгээний үр ашигтай тогтолцоог бий болгох

2.4.5.Эмч эмнэлгийн мэргэжилтнийг ажлын байранд сургаж дадлагажуулах эмнэлзүйн танхимыг байгуулан ажиллуулах

2.4.6.Эмнэлгийн яаралтай тусламжийн нэгдсэн сүлжээ бий болгож, алсын дуудлагад бүх төрлийн тээврийн хэрэгсэл ашиглах нөхцөлийг бүрдүүлж, явуулын болон сэхээн амьдруулах тасгуудын хүчин чадлыг нэмэгдүүлэх

2.4.7.Уламжлалт анагаах ухааныг орчин үеийн анагаах ухааны ололттой хослуулан эмчилгээ, сувилгааны чанар, үр өгөөжийг дээшлүүлж, рашаан сувиллын үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн нэгдсэн удирдлагаар хангах

2.4.8.Гадаад дотоодын уламжлалт эмнэлгүүдтэй хамтын ажиллагаагаа өргөжүүлж уламжлалт анагаах ухааны тусламж үйлчилгээний нэр төрлийг олшруулах

2.4.9.Цахим эрүүл мэндийн төслийг хэрэгжүүлэх, мобайл технологийг эрүүл мэндийн тусламжид нэвтрүүлэх

2.4.10.Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв, нэгдсэн эмнэлгийн лабораторийн тусламж үйлчилгээнд шинэ дэвшилтэт технологийг нэвтрүүлж, эм урвалж, оношлуураар тасралтгүй хангаж, хүний нөөцийг чадавхижуулах

2.4.11.Эмийн чанарт тавих хяналтыг сайжруулж, аюулгүй байдлыг хангаан, эмийн хэрэглээний зохистой дадлыг хэвшүүлэхэд анхаарах

2.4.12.Нийгмийн эрүүл мэндийн онцгой байдал, гамшгийн үеийн нөөцийг бүрдүүлж, бэлэн байдлыг хангах, цус цусан бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангаан сайн дурын авлагагүй донорын эгнээг нэмэгдүүлж нийт хүн амын 1,2 хувийг авлагагүй донор болгоход төрийн болон ТББ-ыг татан оролцуулах, санхүүжилтийг орон нутгаас шийдвэрлэх.

**Зорилт 3.1**: Хүүхэд бүрийг стандартын шаардлагад нийцсэн сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын үйлчилгээнд хамруулж, монгол хэл сэтгэлгээний үндсийг эзэмшүүлэх

**Хэрэгжүүлэх гол үйл ажиллагаа**

3.1.1.Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар баригдсан сургууль, цэцэрлэг болон хүүхдэд чиглэсэн бүхий л үйлчилгээг дэмжин ажиллах

3.1.2.Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээний оновчтой шинэ арга, технологийг судалж, хэрэгжүүлж эхлэх, төгсөлтийн стандартыг жигд хангах

3.1.3.Сүхбаатар аймгийн Боловсрол, соёл урлагийн газрын багш, сурагчдын хөгжлийг дэмжих “Сургах, суралцахуйн төвийг” байгуулах. Олон улсын төсөл хөтөлбөрийн хүрээнд болон орон нутгийн нөөц боломжид тулгуурлан тус төв дээр сургах, суралцахуйн орчин үеийн сургалт, семинарыг зохион байгуулдаг болох, орон нутгийн сургагч багш нарыг бэлтгэх

3.1.4.Сургууль, цэцэрлэгийн хатуу, зөөлөн эдлэл, цэцэрлэгийн хүүхдийн тоглоомыг сэтгэлгээ цаг үед нь тохируулан шинэчлэх, сургуулийн номын санг номоор хангах ажлыг үе шаттай хэрэгжүүлэх

3.1.5.Тэгш хамруулах боловсролын бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор төсвийн санхүүжилт болон олон улсын төсөл хөтөлбөрийн хүрээнд аймгийн сургуулиудын лаборатори, тоног төхөөрөмжийг сайжруулах, хөгжлийн бэрхшээлтэй иргэд суралцах боломжийг хангах сургалтын орчин, хэрэглэгдэхүүний хангамжийг сайжруулах

3.1.6.Сурагчид дотуур байрандаа эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг сайжруулж, бага ангийн 6-8 настай хүүхдэд зориулсан асаргаа, халамж, хөгжлийн үйлчилгээтэй болгох

3.1.7.Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, МСҮТ-д эмч ажиллуулах асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэх, эмч нарыг мэргэжил арга зүйн зөвлөгөөгөөр хангах

3.1.8.Дотуур байрны орчин, үйлчилгээний нөхцөл байдлын судалгааг гаргаж, дотуур байрыг халуун ус, угаалгын үйлчилгээ, номын сан, чөлөөт цагаа өнгөрүүлэх хүүхэд хөгжлийн танхим, тоглоомын өрөөтэй болгох

3.1.9.Бүтээлч сэтгэхүй, идэвхтэй сургалтын арга зүй, холимог сургалтын технологи, ухаалаг боловсролын дэд бүтцийг зохистой хөгжүүлэх нэвтрүүлэх, боловсролын шинэчлэлд багш, сурагчид, эцэг эхийн оролцоо, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх орон нутгийн хөтөлбөр боловсруулах, уялдаа холбоотой төслүүдийг дэмжих аймгийн тусгай сан, тэтгэлэгт хөтөлбөртэй болох

3.1.10.Хүүхдийн бие бялдрын хөгжлийн үзүүлэлтийг шинжлэх ухааны үндэстэй тогтоож хөгжүүлэх, эрүүл мэндийн боловсрол олгох хичээлийн болон хичээлээс гадуурх үйл ажиллагааны арга замыг тодорхойлон хэрэгжүүлэх

3.1.11.Хичээл, сургуулиас гадуурх сонгон, секц, дугуйланг хичээллүүлэх, хүүхдийн авьяас чадварыг нээн хөгжүүлэх

3.1.12.Ерөнхий боловсролын сургуульд сурагчдын амьдрах ур ухааныг хөгжүүлэх, аюулгүй байдлын сургалтыг нэвтрүүлж, хүүхдийг эрсдэлгүй, осол эндэлгүй, эрүүл, аюулгүй амьдрах чадварт сургах

3.1.13.Орон нутгийн үйлдвэрлэл түшиглэсэн үдийн цай, хоол хөтөлбөр гэх мэт орон нутгийн сайн дурын арга хэмжээний хөтөлбөр хэрэгжүүлж бага наснаас нь амьдрал, нийгмийн боловсрол олгох хөтөлбөр хэрэгжүүлэх

3.1.14.Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөнд хүүхдийг хүнлэг, эх оронч, үндэсний ухамсар, бахархалтай иргэн болж төлөвшүүлэхэд чиглэсэн мэдлэг, хүмүүжил олгох агуулгыг тусган хэрэгжүүлэх, эх орноо хайрлах, хүрээлэн байгаа орчноо хамгаалах мэдлэг, хүмүүжил олгох

3.1.15.Олон улсын сурагчдын үнэлгээний /PISA/ шалгуур үзүүлэлтээр бага, суурь боловсролын амжилтыг хэмжиж хэвших

3.1.16.Боловсролын үйлчилгээний үр дүнг сургууль, аймгийн хэмжээнд үнэлдэг тогтвортой механизм бүрдүүлэх

3.1.17.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд чадамж олгох ажлуудыг зохион байгуулах

**Зорилт 3.2**: Хөгжлийн тэргүүлэх чиглэл, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлт, шинжлэх ухаан технологийн дэвшилтэй уялдуулан мэргэжлийн боловсрол, сургалтыг хөгжүүлэх, хувийн хэвшилтэй хамтран төгсөгчдийг ажлын байраар хангах

**Хэрэгжүүлэх гол үйл ажиллагаа**

3.2.1.Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын үйл ажиллагаанд хийх чанарын баталгаажуулалт, хяналтын механизмыг боловсронгуй болгох

3.2.2.Судалгаа, шинжилгээний ажил, үйлдвэрлэлийн шинэ ололтын талаар туршлага бүхий мэргэшсэн багшийн тоог нэмэгдүүлж, аймагт эрэлттэй мэргэжлээр мэргэшүүлэн төгсгөх

3.2.3.Суралцагчдын дадлагын, хичээлийн болон дотуур байрны хүрэлцээ, хангамжийг нэмэгдүүлэх

3.2.4.Төр, хувийн хэвшил, ТББ-уудын түншлэлийн хүрээнд чадамжид суурилсан мэргэжлийн боловсрол, сургалтын хөтөлбөрүүдийг шинэчлэн, мэргэжлийн боловсрол, сургалтын залгамж, уялдааг хангаж, сургалтын арга зүй, орчинг хөгжүүлэх, хөдөлмөрийн зах зээлийн уян бүтцийн хөгжлийг дэмжих

3.2.5.Ажил олгогчдоос захиалга авч, ажлын байран дээр дадлагажиж, төгсөгчийг тухайн ажлын байран дээрээ ажиллах боломжийг хувийн хэвшилтэй хамтран хэрэгжүүлэх

3.2.6.Сүхбаатар аймгийн инновац, энтрепренёршипийн соёлыг төлөвшүүлэх, аж үйлдвэрийн хөгжилд технологийн инновацад тулгуурласан өөрчлөлт авчрах бакалаврын зэрэг олгох 4 жилийн политехник коллежийг байгуулах, хөгжүүлэх

3.2.7.Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийг дэлхийн хөдөлмөрийн зах зээлд нийцсэн салбар дундын мэргэжлийн ур, чадвар, энтрепренер боловсрол олгодог болгон хөгжүүлэх, мэргэжлийн сургалтын төрөл, тоог нэмэгдүүлэх, суралцагчид олгох тэтгэмжийг сурлагын чанартай уялдуулан олгодог болох

3.2.8.Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд суралцагч оюутан залуучуудын эрүүл мэндийг дэмжих ажлыг тогтмол зохион байгуулах

3.2.9.Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн материаллаг баазыг сайжруулжтехнологийн болон мэргэжлийн орчин үеийн мэдлэг, ур чадварыг эзэмшүүлэх, давтан сургах, мэргэжил дээшлүүлэх насан туршийн боловсролын төвбайгуулах.

**Зорилт 3.3**: Мэдээллийн технологийн платформд суурилсан насан туршийн боловсролын тогтолцоог бүрдүүлэх

**Хэрэгжүүлэх гол үйл ажиллагаа**

3.3.1.Насан туршийн боловсролын салбарыг мэргэжлийн, мэргэшсэн багшаар хангах, чадавхжуулах

3.3.2.Иргэдийн эрүүл мэнд, зөв амьдрах, зохистой хооллох, ёс зүй, тогтвортой хөгжлийн боловсрол болон мэдээлэл харилцаа, технологитой ажиллах чадвар, гадаад хэл, аж ахуй эрхлэх мэдлэг чадварыг насан туршийн боловсролоор дамжуулан хөгжүүлэх

3.3.3.Насан туршийн боловсролын төвөөр дамжуулан олгох сургалтын хүртээмж, сургалтын чанарыг сайжруулж шинэ шатанд гаргах

3.3.4.Мэдлэг, иргэний боловсролыг тэнцвэртэй олгох сургалтын хөтөлбөртэй болох

3.3.5.Мэргэжлийн боловсрол, сургалт болон хөдөлмөр эрхлэлтийн ур чадварын сургалтын хамрах хүрээг өргөжүүлж, насан туршийн боловсролын тогтолцоотой уялдуулах

3.3.6.Тогтвортой хөгжлийн боловсрол олгох хөтөлбөр боловсруулан, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, байгууллагаар дамжуулан тогтвортой хөгжлийн боловсролыг бүх нийтэд сурталчлан таниулах

3.3.7.Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, насанд хүрээгүй хүүхэд, ахмад настны мэдээлэл, харилцаа холбооны технологийн зөв зохистой хэрэглээ нэмэгдүүлж, интернэтийн орчинд хамгаалах боломжийг бүрдүүлэх

3.3.8.Насан туршийн боловсрол олгох хөтөлбөрүүдийг зайн сургалтаар явуулахад дэмжлэг үзүүлэх

**Зорилт 3.4**: Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарын хүний нөөцийн тогтвортой бодлогыг хэрэгжүүлж, ажилтны нийгмийн баталгаа хангагдсан хөгжлийг дэмжих тогтолцоог бүрдүүлэх

**Хэрэгжүүлэх гол үйл ажиллагаа**

3.4.1.Багш бүрийн мэргэжлийг дээшлүүлэх, багшийн ур чадвар, бүтээмж, гүйцэтгэлд суурилсан урамшууллын тогтолцоо нэвтрүүлж, "Багш солилцоо" хөтөлбөр хэрэгжүүлэн жил бүр тодорхой тооны багш нарыг гадаадад туршлага судлуулж, ур чадварыг дээшлүүлэх

3.4.2.Салбарын удирдлага, багш, дасгалжуулагч, ажилчдыг мэргэшүүлэх, давтан сургах, туршлага судлах, дотоод гадаадын сургалтад хамруулах ажлыг тогтмол зохион байгуулах, дэмжих

3.4.3.Салбарын байгууллагуудыг мэргэжлийн хүний нөөцөөр хангах бодлого барьж, суманд ажиллаж байгаа хүний нөөцийг дэмжих, чадваржуулах, дахин сургах орон нутгийн хөтөлбөр, тусгай сантай болох

3.4.4.Олон улсын туршлагатай дотоод-гадаадын зөвлөх багш нарыг зочин хэлбэрээр ажиллуулж туршлага нэвтрүүлэн түгээх

3.4.5.Орон нутгийг чадварлаг хүний нөөцөөр хангах, тэднийг тогтвор суурьшилтай ажиллуулахын тулд нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд иргэн, хувийн хэвшилтэй хамтран ажиллах, орон сууцжуулах, түрээсийн орон сууцанд хамруулахад чиглэсэн төсөл, арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх

3.4.6.Салбарын ажилтнуудын эрүүл мэндийг хамгаалах ажлыг сайжруулах, урьдчилан сэргийлэх үзлэгт тогтмол хамруулах

3.4.7.Багшийн ёс зүй, нэр хүнд, үнэлэмжийг дээшлүүлэх, нийгмийн баталгааг хангахад чиглэсэн "Багшийн хөгжил" хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх

3.4.8.Ерөнхий боловсролын сургуулиудад "Сургах, суралцахуйн төв"-ийг байгуулахад дэмжлэг үзүүлэх. Сургахуй, суралцахуйн шинэ технологи, арга зүйг амжилттай нэвтрүүлсэн багш нарыг урамшуулах тэтгэлэг, урамшууллын төсөв, хөтөлбөртэй болох

**Зорилт 3.5**: Бүх нийтийн биеийн тамираар хичээллэх, амралт чөлөөт цагаа өнгөрүүлэх орчин нөхцөлийг сайжруулж, дэд бүтцийн хүртээмжийг нэмэгдүүлж, үндэсний болон олон улсын спортыг хөгжүүлэх

**Хэрэгжүүлэх гол үйл ажиллагаа**

3.5.1.Орон нутгийн уламжлал, давуу тал дээр тулгуурлан үндэсний болон бүс нутгийн спорт, аялал, жуулчлалын зах зээлд гаргах Сүхбаатар аймгийн брэнд спортын арга хэмжээ, бүтээгдэхүүнтэй болох хөтөлбөр боловсруулах, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх сантай болох

3.5.2.Хүн амын суурьшлын бүсүүдэд бүх нийтийн бие тамирын дэд бүтцийг сайжруулах, шинээр барьж байгуулах

3.5.3.Орон нутгийн иргэд багийн спортоор хичээллэх боломж олгох олон зориулалт бүхий задгай спортын талбайнуудын тоог нэмэгдүүлэх

3.5.4.Орон нутгийн иргэд өвлийн улиралд нийтийн бие тамираар хичээллэх, чөлөөт цагаа өнгөрүүлэх боломж, нөхцөлийг дэмжсэн спорт цогцолбор, төвүүдийг нэмэгдүүлэх

3.5.5.Орон нутгийн тэргүүлэх спортын төрлүүдийн мэргэжлийн клубуудыг байгуулах, хөгжүүлэх ажлыг бүх талаар дэмжих, мэргэжлийн тамирчдын хөгжлийг дэмжих тусгай сан байгуулах

3.5.6.Спортын олон төрлийн сургалт арга хэмжээг зохион байгуулах орчин үеийн архитекторын шилдэг шийдэл бүхий, цаашид өргөжүүлэх боломжтой, олон зориулалтаар ашиглах, өртгийн хувьд үр ашигтай спорт цогцолбортой болох

3.5.7.Биеийн тамир, спортоор хичээллэх, бие бялдраа чийрэгжүүлэх орчин, нөхцөлийг хүүхэд, залуучууд, иргэн бүрд хүртээмжтэй хэлбэрээр хөгжүүлэх

3.5.8.Биеийн тамир, спортын арга хэмжээнүүдийг хувийн хэвшлийн оролцоонд тулгуурлан нийгэм-эдийн засагт дарамт багатайгаар тогтмол зохион байгуулах

3.5.9.Аймгийн засаг даргын дэргэд Өсвөрийн шигшээ багийг 10-аас доошгүй төрлөөр байгуулж, дэмжиж урамшуулах

3.5.10.Усан спорт сургалтын төвийн үйл ажиллагааны зардлыг улсын болон орон нутгийн төсөвт суулгаж, хүүхэд залуучуудыг усан спортоор хичээллэх боломж нөхцөлийг бүрдүүлэх

**Зорилт 3.6**: Аймгийн брэнд бүхий соёлын биет бус өв, бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх, соён гэгээрүүлэх ажлыг шинэ шатанд гаргах

**Хэрэгжүүлэх гол үйл ажиллагаа**

3.6.1.Орчин үеийн архитекторын шилдэг шийдэл, дизайн бүхий стандартын шаардлага хангасан соёлын цогцолборт ордон, кино театр,задгай театр болон нүүдлийн соёл иргэншлийг сурталчлах гэр театр, угсаатны зүйн музей, үзэсгэлэнгийн танхим, галлерей, номын сан, хүүхэд залуучуудын ордон зэргийг төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байгуулах

3.6.2.Аймгийн соёл урлаг, өв соёлыг хөгжүүлэх, сурталчлан таниулах Соёл урлагийн хөгжлийн хөтөлбөр, төслүүдийг боловсруулан хэрэгжүүлэх

3.6.3.Соёлын бүтээлч үйлдвэрлэлд оролцоход иргэдийг насан туршийн боловсролын төвөөр дамжуулан бэлтгэж, инновацын ур чадварыг олгох.

3.6.4.Орон нутгийн соёлын бүтээлч аж үйлдвэрийг хөгжүүлэхэд нийтийн салбар, хувийн хэвшлийн салбар, иргэний нийгмийн салбарын хамтын ажиллагааг хөгжүүлэх

3.6.5.Соёлын бүтээлч аж үйлдвэр, чанартай контент үйлдвэрлэлийг дэмжих хөрөнгө оруулалтын сантай болох

3.6.6.Угсаатны онцлогийг илэрхийлсэн гар урлалын брэнд бүтээгдэхүүнүүдийг үйлдвэрлэн зах зээлд нэвтрүүлэхэд маркетингийн удирдлагаар хангах, бодлогоор дэмжих

**Зорилт 4.1**: Гэр бүл, хүүхдэд ээлтэй хөгжил, хамгааллын бодлогыг хэрэгжүүлж, хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлэх замаар хүн амын өсөлт, хөгжлийг дэмжих

**Хэрэгжүүлэх гол үйл ажиллагаа**

4.1.1.Хүүхэд асрах үйлчилгээг асаргаа, хөгжлийн үйлчилгээний хувилбараар хөгжүүлж, дэмжих

4.1.2.Сум бүрд хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын асуудал хариуцсан мэргэшсэн нийгмийн ажилтны орон тоог нэмэгдүүлж, хүүхэд бүртэй тулж ажиллах боломжийг нэмэгдүүлэх

4.1.3.Хүүхэд хамгааллын алба, хамтарсан багийн үйл ажиллагааг сайжруулж, хүүхэд, гэр бүлд чиглэсэн хөгжил, хамгааллын үйлчилгээний хүрээ, нэр, төрөл, чанарыг өргөжүүлэх, гэр бүлийн боловсролыг нэмэгдүүлэх, бодлого, хөтөлбөр хэрэгжүүлэх

4.1.4.Аймаг, сумын Хүүхдийн төлөө зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулж, хүүхдийн хөгжил хамгааллын асуудлаар салбар дундын хамтын үйл ажиллагааг сайжруулах, энэ чиглэлээр түншлэлийг хөгжүүлэх

4.1.5.Тамирчид, сурагчдыг төрөл бүрийн уралдаан тэмцээнд бэлтгэхэд шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах, нэн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, санхүүгийн дэмжлэг үзүүлэхэд төр хувийн хэвшлийн байгууллагууд, иргэний оролцоог дэмжлэгт орчныг бүрдүүлэх

4.1.6.Бага насны хүүхдийг эрүүл аюулгүй хоол хүнсээр хангах, түүнд эцэг эхийн оролцоо, хяналтыг нэмэгдүүлэх

4.1.7.Сум, сургууль бүрийг хүүхдийн номын сантай болгох, хүүхэд чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх төвүүдийг нээн ажиллуулах

4.1.8.Ардын өв соёлыг өвлүүлэх, хүүхдийн эх оронч, үндэсний үзлийг төлөвшүүлэхэд чиглэсэн сургалт нөлөөллийн ажлыг зохион байгуулах, хөгжим, бүжиг, урлагаар хүмүүжүүлэх орчныг бүрдүүлэх

4.1.9.Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрээс урьдчилан сэргийлж, энэ талын хүүхдийн эрхийн зөрчил гаргахгүй байх нөхцөлийг бүрдүүлэх

4.1.10.Хүүхдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх

4.1.11.Хүүхдийг гэр орон, сургууль, нийгмийн бусад нөхцөлд хүчирхийлэл, эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг иргэд, хамт олон, байгууллагуудын оролцоотой хэрэгжүүлэх

4.1.12.Хүчирхийлэлд өртсөн хүүхэд, эмэгтэйчүүдэд нийгэм, сэтгэл зүйн дэмжлэг, тусламж үзүүлэх нөхцөлийг бүрдүүлэх

4.1.13.Хүүхэд, залуучуудын хөгжил оролцоог дэмжсэн нийгмийн орчинг бүрдүүлэх зорилгоор “Гэр бүлийн хөгжлийн ордон”, “Хүүхдийн зуслан”, “Хүүхдийн парк” зэргийг байгуулж, үйл ажиллагааг идэвхижүүлэх,

4.1.14.Сум бүрийн төсөвт хүүхэд хамгааллын үйлчилгээнд шаардагдах хөрөнгийг тусгах, хүүхэд хамгааллын хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах

4.1.15.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан нөхөн сэргээх төв болон ганцаарчилсан сэтгэлзүйн төвтэй болох, шаардлагатай хүний нөөцөөр хангах

4.1.16.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тэгш хамруулан сургах нөхцөл бололцоог дэмжиж, ердийн сургуульд тусгай бүлгийг нээн ажиллуулах

4.1.17.Дэлгэцийн донтолт, архи, тамхи, мансууруулах бодисын хор нөлөө, хүчирхийлэл, дарамт, шахалт, эрсдэлд өртөхөөс сэргийлэх талаар хүүхэд, өсвөр үеийнхэнд зориулсан сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг тогтмол зохион байгуулах

4.1.18.Хүүхдэд ээлтэй, эрүүл, аюулгүй орчин бүрдүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, байгууллагын хамтын ажиллагааг эрчимжүүлэх

4.1.19.Хүүхдийн хөгжил, төлөвшил, хүмүүжилд сөрөг нөлөө үзүүлж болох хүчин зүйлсийг тогтоох, түүнээс урьдчилан сэргийлэх талаар эцэг, эх, асран хамгаалагч, багш нарын мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх

4.1.20.Сургалтын байгууллагын багш, ажилтан суралцагчдын эрсдэлт нөхцөлд байгаа эсэхийг үнэлэх, судлах, зөвлөгөө өгөх үйлчилгээг тогтмолжуулах

4.1.21.Сургууль, гэр бүлийн орчинд хүүхдийн хүн болж төлөвшихөд чиглэсэн хүүхдийг сонсох, үзэл бодлыг нь хүндэтгэх нийгмийн хандлагыг төлөвшүүлж, бодлого төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх үйл явцад хүүхдийн оролцоог нэмэгдүүлэх

**Зорилт 4.2**: Залуучуудын гэр бүл төлөвлөлтийн талаарх мэдлэгийг дээшлүүлж, гэр бүлийн тогтвортой байдлыг хангах, залуучуудыг түүх, соёл, зан заншил, уламжлалаа мэддэг, эх оронч үзэлтэй, бие даан амьдрах чадвартай, хариуцлагатай иргэн болгон төлөвшүүлэхэд нийгмийн үйлчилгээг чиглүүлж, залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих

**Хэрэгжүүлэх гол үйл ажиллагаа**

4.2.1.Өрх толгойлсон, олон хүүхэдтэй, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй, бага орлоготой эцэг, эхийн амьжиргааг дээшлүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэх

4.2.2.Залуучуудын гэр бүл төлөвлөлт, залуу гэр бүлийн тогтвортой байдал, гэр бүлийн гишүүдийн эерэг харилцаа, уламжлал, зан заншлын тухай утга зохиол, уран сайхны бүтээл, нөлөөллийн ажлуудыг дэмжих

4.2.3.Сумын залуучууд, гэр бүл, хүн амын хөгжлийн асуудал хариуцсан мэргэжилтэн, нийгмийн ажилтныг мэргэшүүлэх

4.2.4.Гэр бүлийн үнэ цэнэ, хамтын амьдралын утга учир, эцэг, эхийн хамтын үүрэг, хариуцлагыг таниулах чиглэлээр үр дүнтэй арга хэмжээг зохион байгуулж, үр хүүхдээ хөдөлмөрч, шударга, ёс суртахуунтай иргэн болгон төлөвшүүлэн хүмүүжүүлж байгаа гэр бүлийг сурталчлах, урамшуулах

4.2.5.Гэр бүлийн үнэт зүйлсийг бэхжүүлж, хүчирхийллийг бууруулах, гэр бүлийн гишүүдийн хариуцлагыг нэмэгдүүлэхэд чиглэсэн нөлөөллийн ажлыг зохион байгуулах

4.2.6.Үндэсний цөөнх, шилжин суурьшигч, зорилтот бүлгийн, хөдөө орон нутагт ажиллаж, амьдарч байгаа залуучуудын боловсролын хэрэгцээг судалж, хэрэгцээнд суурилсан сургалтыг насан туршийн боловсролын хөтөлбөрөөр дамжуулан эзэмшүүлэх

4.2.7.Биеийн тамир, спорт, амралт, алжаал тайлах, бялдаржуулалт, бясалгалын төв, номын сан зэрэг залуучуудын бие бялдар, сэтгэхүйг хөгжүүлэх үйлчилгээг нэвтрүүлэхийг дэмжих

4.2.8.Залуучуудын гарааны бизнесийг дэмжих бизнес инкубацийн үйлчилгээ үзүүлэх

4.2.9.Залуу малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт зохион байгуулах

4.2.10.Гадаадад болон нийслэлд ажиллаж байгаа ур чадвар, ажлын туршлага, технологи дамжуулах чадвар бүхий залуучууд нутагтаа эргэн ирж ажиллахад дэмжих

4.2.11.Залуучуудын орлоготой нийцүүлэн, уян хатан төлбөрийн нөхцөлөөр орон сууц худалдаж авах, хөлслөх, залуу гэр бүлийг орон сууцжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хувийн хэвшлийн болон банкны байгууллагуудтай хамтран ажиллах

4.2.12.Залуучуудыг түүх, соёлоо мэддэг, эх оронч үзэлтэй, бие даан амьдрах чадвартай, хариуцлагатай иргэн болж төлөвшихөд дэмжлэг үзүүлэх

**Зорилт 4.3**: Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан дэд бүтцийг сайжруулж, тэдэнд нийгмийн хамгаалал, халамжийн үйлчилгээг жигд тэгш хүргэх, хөгжилд хувь нэмрээ оруулан бие даан амьдрах таатай орчинг бүрдүүлэх

**Хэрэгжүүлэх гол үйл ажиллагаа**

4.3.1.Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн онцлогт нийцсэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажлын байр бий болгосон ажил олгогчийг урамшуулж, ажлын байрыг тогтвортой хадгалах бодлогыг баримтлах

4.3.2.Тэтгэвэрт гарахын өмнө болон гарсны дараах сургалтын төв, дамжаа, ангийг үүсгэн байгуулж, сургалтын хөтөлбөрийг боловсруулах, сургалт зохион байгуулах, ахмад настанд сэтгэл санааны бэлтгэл хангахад дэмжлэг үзүүлэх

4.3.3.Хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ахмад настны сайн дурын болон үүсгэл санаачилгын байгууллага, тэдэнд үйлчлэх төв, настны хөгжлийн төв, клуб зэрэг төрөл бүрийн байгууллагуудын талаар сайн туршлагыг судалж, боломжит хэлбэрүүдийг нутагшуулан хэрэгжүүлэх

4.3.4.Хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ахмад настанд зориулсан асрамжийн үйлчилгээг өргөжүүлэх, гэрээр үзүүлэх олон мэргэжлийн багийн тусламжийн хамрах хүрээг нэмэгдүүлэх, чанарыг сайжруулах, салбар дундын үйл ажиллагааг хэрхэн уялдуулан зохицуулах

4.3.5.Хүний хөгжлийн төвүүдийг байгуулж, бүтэц, зохион байгуулалтад эрүүл насжилт, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ахмад настны эрүүл мэндийг дэмжих нэгж, хэсгийг оруулах

4.3.6.Хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх арга техникт /сонсгол, хараа, хөдөлгөөн шалгах сорил/ эцэг эхчүүд, цэцэрлэгийн багш нарыг сургах

4.3.7.Нярайг хараа, сонсгол, түнхний мултрал, бодисын солилцооны эмгэгийг эрт илрүүлэх үзлэгт бүрэн хамруулах боломжийг бүрдүүлэх

4.3.8.Геронтологи, гериатрийн мэргэжлээр хүний нөөц бэлтгэх, чадавхыг дээшлүүлэх

4.3.9.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч буй эцэг, эхийг хуульд заасан тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, тусламж үйлчилгээнд бүрэн хамруулах

21

4.3.10.Хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ахмад настны хөгжлийг дэмжих, нийгмийн баталгааг хангах зориулалт бүхий сан байгуулах

4.3.11.Нутгийн захиргааны байгууллагуудын дэд бүтцийн хүртээмжийн байдалд үнэлгээ хийж, стандартад нийцүүлэх арга хэмжээ авах

**Зорилт 4.4**: Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцаан дахь жендерийн эрх тэгш байдлыг хангаж, нийгмийн амьдралд оролцох оролцоог дээшлүүлж, шийдвэр гаргах бүх түвшинд эмэгтэйчүүдийн эзлэх хувь хэмжээг нэмэгдүүлэх

**Хэрэгжүүлэх гол үйл ажиллагаа**

4.4.1.Аливаа төлөвлөлт, төсөвлөлт бүрийг жендэрийн мэдрэмжтэй боловсруулах, баталж, санхүү, цалин, нийгэм хамгааллын бодлогыг батлан хэрэгжүүлэхэд тэгш байдлыг хангах

4.4.2.Ажил олгогчдод ажлын байран дахь эрх тэгш байдлын тухай мэдлэг олгоход чиглэсэн сургалт, нөлөөллийн ажлуудыг зохион байгуулах

4.4.3.Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, гэрийн хөдөлмөрийг хөнгөвчлөхөд чиглэсэн технологийн дэвшлийг нэвтрүүлэх, дэмжих

4.4.4.Бүх шатны боловсролын байгууллагын сургалтын хөтөлбөрт жендерийн болон жендерт суурилсан хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийллийг үл тэвчих ойлголт, хандлагыг төлөвшүүлэх асуудлыг тусгах

4.4.5.Бусдыг хүндлэх, гэр бүлийн болон ойр дотны хүнээ хайрлан хүндлэх, хүнлэг чанарыг эрхэмлэх, эрүүл амьдралын зан үйлд суралцаж хорт, буруу зуршлаас ангижрах арга ухааныг төлөвшүүлэх чиглэлээр сургалт, сурталчилгааг тасралтгүй явуулах

4.4.6.Жендэрийн шууд болон шууд бус ялгаварлан гадуурхалтыг бууруулж, түүнээс урьдчилан сэргийлэх орчинг бүрдүүлж, жендэрийн эрх тэгш байдал зөрчигдсөн тухай гомдлыг шуурхай хянан шийдвэрлэж хэвших

4.4.7.Эмэгтэйчүүдийг шийдвэр гаргах түвшинд ажиллахад бэлтгэх, чадавхижуулах, манлайллыг бий болгох, сургалт сурталчилгаа явуулах чиглэлээр төрийн бус байгууллагатай хамтран ажиллах

**Зорилт 5.1**: Эдийн засгийг төрөлжүүлэн хөгжүүлж, түүний өсөлтийг тогтворжуулан улсын төсвөөс хамааралтай байдлыг бууруулах

**Хэрэгжүүлэх гол үйл ажиллагаа**

5.1.1.Эдийн засгийн бүх салбарт гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдыг хөхүүлэн дэмжих, технологийн шинэчлэл хийх, орон нутгийн хөгжлийн тэргүүлэх чиглэлтэй уялдсан хөрөнгө оруулалтын оновчтой бодлогыг хэрэгжүүлэх;

5.1.2.Урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхдээ төр, хувийн хэвшлийн түншлэлийн зарчимд тулгуурлан, олон улсын байгууллага болон гадаадын урт хугацаатай, хөнгөлөлттэй зээлийг түлхүү ашиглаж, олон улсын санхүү, эдийн засгийн байгууллагуудтай бодлогоо уялдуулж, идэвхтэй хамтран ажиллах;

5.1.3.Орон нутагт санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх хөтөлбөрийг боловсруулан батлуулж, хэрэгжүүлэх;

5.1.4.Иргэдийн санхүүгийн боловсрол, бизнес эрхлэх мэдлэг, мэдээллийн дээшлүүлэхэд чиглэсэн сургалт, сурталчилгааны ажлуудыг зохион байгуулах;

5.1.5.Хилийн боомтын үйл ажиллагааг өргөжүүлж, хөрөнгө оруулалтыг дэмжих, боомтын материаллаг бааз, мэргэжлийн боловсон хүчнээр бэхжүүлж ажиллах, худалдаанаас орох орлогыг нэмэгдүүлэх;

5.1.6.Гаалийн шалган нэвтрүүлэх хүчин чадлыг сайжруулах зорилгоор тээврийн хэрэгсэлд зориулсан өндөр хүчин чадал бүхий тандан илрүүлэх төхөөрөмж суурилуулах

5.1.7.Хөрш орны хил залгаа хотуудтай идэвхитэй үйл ажиллагаа явуулж гадаад худалдааны таатай орчин бүрдүүлэх;

5.1.8.Тусгай сангуудын зарцуулалт, үйл ажиллагааг үр дүнтэй, ард иргэдэд нээлттэй, ил тод болгох

**Зорилт 5.2**: Бизнес эрхлэх таатай орчин, дэд бүтцийг бүрдүүлж, нэмүү өртгийн сүлжээ бүхий технологи, инновацын ололтод суурилсан эдийн засгийн үр ашигтай орон нутгийн эко бизнес, үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээг хөгжүүлэх

**Хэрэгжүүлэх гол үйл ажиллагаа**

5.2.1.Орон нутгаас тогтоох татвар төлбөр хураамжийг тодорхой шалгуурт нийцүүлэн зохистой байдлаар тогтоох, тусгай зөвшөөрөл олгох тогтолцоог хялбаршуулан, төрийн хяналт шалгалтыг зөвлөн дэмжих зарчимд суурилан хөгжүүлэх замаар бизнес эрхлэх таатай орчныг бий болгох

5.2.2.Орон нутгийн бизнес эрхлэгчдэд гадаад харилцааг өргөтгөх, туршлага хуримтлуулахад нь дэмжлэг үзүүлэх;

5.2.3.Хүнд үйлдвэрийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрт тусгагдсан Хөөтийн аж үйлдвэрийн паркийг байгуулж, уул уурхай, боловсруулах үйлдвэр, нүүрс, химийн үйлдвэр хөгжүүлэхэд орон нутгийн оролцоог тодорхойлж, идэвхтэй хамтран ажиллах;

5.2.4.Үйлдвэрлэл технологийн паркийг өргөтгөж, түүнд түшиглэн хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэр, цех байгуулах иргэн, аж ахуй нэгжид дэмжлэг үзүүлэх, түүхий эдийг хангадаг хоршоодыг аймгийн хэмжээнд хөгжүүлэх

5.2.5.Үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, бараа, бүтээгдэхүүнийг олон улсын худалдааны болон цахим худалдааны сүлжээнд хамруулах боломжийг судалж, борлуулалтыг нэмэгдүүлэх

5.2.6.Арьс шир, малын гаралтай дайвар бүтээгдэхүүн, ноос, ноолуурыг боловсруулах, нэмүү өртгийн сүлжээг бүрдүүлж, хөрөнгө оруулалтаар дэмжих, түүхий эдийн бэлтгэл, тээвэрлэлтийг боловсронгуй болгож, бусад бүсийн үйлдвэрт тогтвортой нийлүүлэх;

5.2.7.Барилгын материалын үйлдвэрлэлийн хэмжээ, нэр төрлийг нэмэгдүүлж, чанар стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүн үйлдвэрлэх;

5.2.8.Мал, мал аж ахуйн түүхий эд бүтээгдэхүүний төрөлжсөн зах, тээвэр логистикийн терминал бий болгож, агуулахуудыг аймгийн хэмжээнд бүсчлэн хөгжүүлэх;

5.2.9.Хөнгөн болон хүнсний үйлдвэрийн хүний нөөцийн эрэлт хэрэгцээнд нийцсэн мэргэжилтэй ажилтны хүртээмжийг нэмэгдүүлэх;

5.2.10.Бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчийн өртөг шингэсэн үйлдвэрлэл эрхлэх, нэмүү өртгийн сүлжээнд хамрагдах санаачилгыг түлхүү дэмжиж, зээл, санхүүгийн хөнгөлөлттэй бодлого хэрэгжүүлэх;

5.2.11.5-аас доошгүй жил тасралтгүй үйл ажиллагаа эрхэлж, байнгын ажлын байр шинээр бий болгосон хөнгөн, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг урт хугацаатай, хөнгөлөлттэй зээлээр дэмжих;

5.2.12.Чиглэлийн яамд, холбогдох байгууллагуудтай хамтран уян хатан нөхцөлтэй зээлээр хөнгөн үйлдвэр, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг дэмжих арга хэмжээг хэрэгжүүлэх;

5.2.13.Бизнесийн зөвлөх үйлчилгээ үзүүлэгчдийн чадавхийг сайжруулах, хүртээмжийг нэмэгдүүлэх

**Зорилт 5.3**: Унаган байгаль, түүх, соёл, нүүдэлчин ахуйг түшиглэсэн хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд суурилсан эко бизнес, хил орчмын аялал жуулчлалыг эрчимтэй хөгжүүлэх

**Хэрэгжүүлэх гол үйл ажиллагаа**

5.3.1.Аймгийн аялал жуулчлалын салбарын судалгаа, шинжилгээ хийж, зөвлөх үйлчилгээ авч, урт хугацааны хөгжлийн стратегийг боловсруулан хэрэгжүүлэх

5.3.2.Үйлчилгээний менежментийн зөвлөх үйлчилгээний байгууллагатай гэрээ байгуулах замаар аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа бүх үйлчилгээний байгууллагын өнөөгийн түвшинг үнэлэх, мэргэжлийн зөвлөгөө авах, цаашид үе шаттай хөгжүүлэх дэд хөтөлбөр боловсруулах, хүний нөөцийг чадавхжуулах төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх

5.3.3.Баруун-Урт хотын аялал жуулчлалын имижийг бүрдүүлэх

5.3.4.Зан заншил, уламжлал, нүүдэлчин ахуйд түшиглэсэн аялал жуулчлалын имижийг бүрдүүлж, эко аялал жуулчлалын бүтээгдэхүүн, бүс, маршрутыг тодорхойлох, мэдээлэл танилцуулгын гэрэлт самбаруудыг байршуулах, аялал жуулчлалын хог хаягдлын менежментийг шийдвэрлэх, нутгийн аж ахуйн нэгж, иргэдтэй хамтран хөгжүүлэх

5.3.5.Нутгийн иргэдийн байгаль орчин, аялал жуулчлал, үйлчилгээний менежментийн талаарх боловсрол, мэдлэгийг дээшлүүлэх, нутгийн онцлогийг илэрхийлсэн гар урлалын бүтээгдэхүүн үйлдвэрлэх өрхийн үйлдвэрлэлийг дэмжих, урлаг, урлаг соёлын үйлчилгээ үзүүлэх өрхүүдийг тодорхойлж чадавхижуулах, малчдын ахуй амьдралтай танилцах орчин бүрдүүлэх замаар орон нутгийн хөгжил, ард иргэдэд орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх

5.3.6.Орон нутгийн өв соёлыг сурталчлан таниулах эвент арга хэмжээг зохион байгуулж, маркетинг, сурталчилгааг хөгжүүлэх;

5.3.7.Төр хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлж, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татах замаар стандартын шаардлага хангасан жуулчны баазыг байгуулж, жуулчдын ая тухыг хангах орчныг бүрдүүлэх;

5.3.8.Аялал жуулчлалын хөрөнгө оруулалтыг дэмжих, мэргэшсэн, чадварлаг баг, компаниудыг ирж ажиллах сонирхлыг татах бодлого баримтлах нутгийн иргэдийг сургаж ажиллуулах, зарим бараа, ажил, үйлчилгээг ханган нийлүүлэх нөхцөлтэйгөөр аялал жуулчлалын зөвшөөрөл олгох;

5.3.9.Аялал жуулчлалын гол чиглэлийн дагуу зам харилцаа, холбоо, эрчим хүчний хангамжийг сайжруулах, авто зогсоол, үйлчилгээний төв, ариун цэврийн байгууламжийн олон улсын стандартад нийцүүлэн бий болгох;

5.3.10.Хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлэн, гадаад жуулчны урсгалыг нэмэгдүүлэх

5.3.11.Хууль зөрчиж, байгаль орчинд халтай аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулсан этгээдийн хүлээх хариуцлагыг чангатгах, дүрэм, журмыг чанд сахиулах

**Зорилт 5.4**: Технологи, инновацад суурилсан өрсөлдөх чадвартай, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн загвар аймаг болох

**Хэрэгжүүлэх гол үйл ажиллагаа**

5.4.1.Мал сүргийн бүтцийн зохистой бодлого явуулж, нийт малын тоог тогтвортой түвшинд барих, бод малын эзлэх хувийг нэмэгдүүлэх, илүүдэл малыг эдийн засгийн эргэлтэд оруулах

5.4.2.Малын чанар, үүлдэрлэг байдлыг сайжруулж, нэгжийн ашиг шимийг дээшлүүлэх зорилгоор малын чанар, үржлийн ажлыг сайжруулах хөтөлбөр хэрэгжүүлэх

5.4.3.Үзэмчин хонь, Баяндэлгэрийн улаан ямаа, Дорнод монголын улаан үхэр зэрэг баталгаажсан үүлдэр, омгийн малын цөм сүргийг өсгөх, сум бүрд бог малын хээлтүүлэгчийг үржүүлэг, технологийн нэгжид төвлөрүүлэх

5.4.4.Өндөр ашиг шимтэй мах, сүүний чиглэлийн үүлдрийн үхэр, гахай, шувууны эрчимжсэн аж ахуйг хөгжүүлэхэд бодлогын болон санхүүгийн дэмжлэг үзүүлэх

5.4.5.Бэлчээрийн менежментийг сайжруулах, бэлчээрийн төлөв байдлыг үнэлэх, хянах ажлыг зохион байгуулж, бэлчээрийг хуваарьтай ашиглах, усжуулах

5.4.6.Байгаль, экологийн онцлогтой уялдуулан бэлчээр нутагт бүсчлэл тогтоож, отрын бүс байгуулах, ногоон хөгжлийг дэмжих

5.4.7.Малын тэжээлийн баазыг өргөтгөх, хүчит, багсармал холимог тэжээлийн үйлдвэр байгуулах, тэжээлийн нэмэлт үйлдвэрлэх, ногоон тэжээл, даршны үйлдвэрлэл, хэрэглээг нэмэгдүүлэх

5.4.8.Эрчимжсэн мал аж ахуйг зориулалтын тэжээлээр хангах, уургийн өндөр агууламжтай таримлыг нутагшуулах, сортын үрийн нөөц бүрдүүлэх

5.4.9.Малын тэжээллэгийн талаарх мэдлэг, ур чадварыг дээшлүүлж, тэжээлийн зохистой хэрэглээг дэмжих

5.4.10.Өвс, хадлан бэлтгэх техник, тоног төхөөрөмжийг сайжруулж, өвс, тэжээлийн аюулгүйн нөөц, агуулахыг тодорхой сумдад бий болгох

5.4.11.Нар, салхины сэргээгдэх эрчим хүчийг ашиглан газрын гүнээс ус татах тоног төхөөрөмжийг хуучин инженерийн хийцтэй худгуудыг засварлан суурилуулах, худаг гаргах үйл ажиллагаанд шинэ дэвшилтэт техник технологи нэвтрүүлэн бэлчээр усжуулалтыг нэмэгдүүлэх

5.4.12.Мал, амьтанд тандалт шинжилгээг тогтмол явуулж, халдварт өвчингүй тайван байдлыг баталгаажуулж, эрүүл тусгаарлагдсан бүсийг тогтоон, хяналтад авах

5.4.13.Хилийн хяналтын үйл ажиллагааг сайжруулж, дамжин өнгөрөх бүс болон орон нутгийн төв замуудад ариутгал халдваргүйтгэлийн иж бүрэн байр барьж ашиглалтад оруулах

5.4.14.Мал эмнэлгийн стандарт хангасан нэгжүүдийн үйл ажиллагааг дэмжих, судалгаа шинжилгээ, оношилгоо, эрүүл ахуй, ариун цэвэр, сорилт баталгаажуулалтын лабораторийн нөхцөлийг сайжруулах

5.4.15.Мал, амьтнаас хүнд дамжин халдварладаг зооноз өвчинтэй тэмцэх, хяналтад авах арга хэмжээг эрүүл мэндийн салбартай хамтран зохион байгуулж, халдвар авах эрсдэл бүхий иргэдэд өвчний талаар мэдлэг олгох сургалтыг явуулах

5.4.16.Сум бүрд мал эмнэлгийн тархвар зүйч нарыг бэлтгэн, тархвар зүйн судалгаа хийх, мэдээллийн сан бүрдүүлэх нөхцөлийг бүрдүүлж, судалгааны дүнд тулгуурлан тархвар зүйн зураглалыг шинэчлэх

5.4.17.Малын үржлийн бүртгэл мэдээллийн сан бүрдүүлж, шилжилт хөдөлгөөнийг хяналтад авч, цахим мэдээллийн системийг нэвтрүүлэх

5.4.18.Мал эмнэлгийн шуурхай бэлэн байдлыг хангах, сайжруулах зорилгоор автомашины парк шинэчлэлийг хийж, гоц халдварт өвчний үед ажиллах нөөцийг бүрдүүлэх

5.4.19.Мах, сүү, арьс шир, ноос ноолуур зэрэг малын гаралтай бүтээгдэхүүнд тавих ариун цэвэр, эрүүл ахуйн хяналтыг сайжруулах замаар өрсөлдөх чадвартай, органик бүтээгдэхүүн үйлдвэрлэх

5.4.20.Малын гаралтай бүтээгдэхүүний анхан шатны болон гүнзгий боловсруулалтыг сайжруулж, өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэл болон зах зээлд нийлүүлэх бодлогыг дэмжих, нэгдсэн маркетинг хэрэгжүүлэх;

5.4.21.Махны экспортыг тогтвортой, урт хугацаанд төлөвлөн тодорхойлох, зах зээлийг өргөтгөх, шинэ зах зээлийг нээх, үйлдвэрлэлийн аргаар боловсруулсан махны бэлэн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортыг нэмэгдүүлэх;

5.4.22.Сүүний нөөц ашиглалтыг сайжруулж, үйлдвэрийн аргаар боловсруулсан сүүний хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор орон нутагт сүү, сүүн бүтээгдэхүүний бага, дунд оврын загвар үйлдвэр байгуулахад дэмжлэг үзүүлэх;

5.4.23.Хүн амын хүнсний аюулгүй байдлыг хангах зорилгоор мал, амьтны гаралтай бүтээгдэхүүнд антибиотик эмийн үлдэгдлийг тодорхойлох оношилгоо, шинжилгээний чадварыг сайжруулж, мал, амьтны эмийн зохистой хэрэглээг хэвшүүлэх

5.4.24.Мал аж ахуйн мэргэжилтнийг бодлогоор бэлтгэх, давтан сургах, тэдний нийгмийн асуудлыг шийдвэрлэх мал аж ахуйн хөгжлийн талаарх олон улсын туршлагыг судлах, нэвтрүүлэх

5.4.25.Мал аж ахуйн мэргэжилтний хөгжлийн төв байгуулах, экстэйншний үйлчилгээг өргөтгөх

5.4.26.Тариалангийн талбайн ашиглалтыг сайжруулж, атаршсан талбайг эдийн засгийн эргэлтэд оруулах

5.4.27.Эдийн засгийн үр ашигтай, хөрсний үржил шимд ээлтэй ургамал, сортыг нутагшуулах, үрийн аж ахуйн тогтолцоог сэргээн хөгжүүлэх замаар үр тариа, буурцагт болон тэжээлийн таримлын төрөл, сортыг нэмэгдүүлэх

5.4.28.Улаан буудай, төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ, тосны ба тэжээлийн ургамлын үйлдвэрлэлээр дотоодын хэрэгцээг бүрэн хангах, улмаар экспортын чиг баримжаатайхөгжүүлэх

5.4.29.Өвөл, зуны хүлэмжийн болон зоорины аж ахуйг хөгжүүлэн хүнсний ногооны тариалалтыг нэмэгдүүлж, хүн амыг жилийн турш шинэ ургацын ногоогоор тогтвортой хангах

5.4.30.Хөрс боловсруулах тэг элдэншүүлгийн технологийг үйлдвэрлэлд үе шаттайгаар нэвтрүүлэх болон тариалах хугацаа, суулгалтын гүн, хортон шавжтай тэмцэх арга хэмжээг байгаль цаг уурын нөхцөлтэй уялдуулах

5.4.31.Хөрсөнд тохирсон сортын үр, бордоо хэрэглэх, химийн гаралтай ба био бордоо, ургамал хамгааллын бэлдмэлийн цогц арга хэмжээг хэрэгжүүлэх, түүнд тавих хяналтыг төлөвшүүлэх

5.4.32.Хамгаалагдсан хөрсний тариалалтыг нэмэгдүүлэх

5.4.33.Усны хайгуул, судалгаанд тулгуурлан гадаргын болон бороо, цасны усыг хуримтлуулах, төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнийн тариалалтад ус, эрчим хүчний зарцуулалт багатай, байгаль орчинд халгүй дуслын болон хөрсөн доороос нэвчүүлэх усалгааны дэвшилтэт технологийг нэвтрүүлэх услалтын системийн ашиглалтыг сайжруулах, усалгаатай тариалангийн талбайн хэмжээг нэмэгдүүлэх

5.4.34.Төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнийн хадгалалт, зоорь агуулахын хангамжийг нэмэгдүүлэх, борлуулалтын сүлжээний менежмент, бүтцийг боловсруулж нэвтрүүлэх

**Зорилт 5.5**: Байгалийн нөөц, ашигт малтмалын баялагт суурилсан ил тод, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх замаар орон нутгийн хөгжлийг дэмжиж бүсийн эдийн засгийн тулгуур төв болох

**Хэрэгжүүлэх гол үйл ажиллагаа**

5.5.1.Ашигт малтмалын хайгуул судалгааны ажлыг үргэлжлүүлж, геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлыг нэмэгдүүлэх;

5.5.2.Хөөтийн нүүрсний орд, Шинэ Ерөөлтийн нүүрсний орд зэрэг орон нутагт эдийн засгийн ач холбогдол бүхий томоохон орд газруудын ТЭЗҮ шинэчлэх ажлыг аж үйлдвэрийн парк байгуулах зорилттой уялдуулан авч үзэж, бодлогоор дэмжих;

5.5.3.Ил тод, хариуцлагатай уул уурхай, ашигт малтмалын бодлогыг эрхэмлэж, хүний эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатай техник, технологийг ашигласан, орон нутгийн хөгжлийг тэтгэсэн үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжийг дэмжих;

5.5.4.Уул уурхайн дүйцүүлэн нөхөн сэргээлтийн төслийг үе шаттай хэрэгжүүлэхэд санаачилга гарган ажиллах;

5.5.5.Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газар, газрын хэвлийг ашиглагч нь хамгаалах, нөхөн сэргээх зарчмыг хэрэгжүүлж, биелэлтэд нь хяналт тавих;

5.5.6.Уул уурхайн компаниудын нөхөн сэргээлтийн үйл ажиллагаа сайжруулах, эвдэрч эзэнгүй орхигдсон газрын тооллогыг жил бүр хийж, техник, биологийн болон дүйцүүлэн нөхөн сэргээлтийн ажилд төсөл хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр тусгай зөвшөөрөлтэй хувийн хэвшлийн оролцоог хангаж ажиллах;

5.5.7.Түгээмэл тархацтай ашигт малтмалын хууль бус олборлолтыг зогсоох, нийгэм-эдийн засаг-байгаль орчны шаардлага, батлагдсан нөөцөд тулгуурлан орд карьерыг эзэмшүүлэх, ашигласны төлбөр үнэлгээг шинэчлэн мөрдүүлэх

**Зорилт 6.1**: Шинэ технологи, сэргээгдэх эрчим хүчийг нэвтрүүлж хэрэглээг дэмжих, тогтвортой үйлдвэрлэлийг хөгжүүлэх

**Хэрэгжүүлэх гол үйл ажиллагаа**

6.1.1.Сэргээгдэх эрчим хүчний нөөц, үйлдвэрлэлд хэрэгжүүлэх боломжийн судалгаа хийх, хувийн хэвшил, олон улсын байгууллагаас хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг нэмэгдүүлэх, хамтран ажиллах;

6.1.2.Эрчим хүчний хэмнэлттэй болон сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрээр хэрэглэгчийг цахилгаан ба дулаанаар хангах боломжийг судлах;

6.1.3.Орон нутагт эрчим хүчний шинэ эх үүсвэр бий болгох дотоод, гадаадын төсөл, хөтөлбөрүүдийг дэмжин идэвхи санаачилга гаргаж хамтран ажиллах;

6.1.4.Аялал жуулчлалын гол цэгүүдийг тодорхойлж тэдгээрийг уламжлалт болон сэргээгдэх эрчим хүчээр хангахад дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах;

6.1.5.Сум орон нутаг, малчин өрхүүдийг уян хатан, хөдөлгөөнт тогтвортой сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг ашиглах нөхцөлийг дэмжих;

6.1.6.Эрчим хүчний түгээх болон дамжуулах сүлжээний алдагдлыг бууруулах, хэрэглэгчдэд эрчим хүчний хэмнэлттэй хэрэглээний дадал зуршлыг хэвшүүлэх ажлыг шат дараатай хэрэгжүүлэх.

6.1.7.Аймгийн хэмжээнд барилга байгууламж, инженерийн шугам сүлжээний нэгдсэн мэдээллийн сантай болох

**Зорилт 6.2**: Хот байгуулалт, инженерийн дэд бүтцийг сайжруулан, иргэдийн эрүүл аюулгүй тохилог орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх

**Хэрэгжүүлэх гол үйл ажиллагаа**

6.2.1.Хотын ерөнхий төлөвлөгөөний замын сүлжээ, инженерийн шугам сүлжээтэй уялдуулан эмхлэн, цэгцэлж бүх төрлийн үйлчилгээний хангамж, тохижилтыг сайжруулан гэр хорооллын дахин төлөвлөлт хийх, гэр хорооллын дэд бүтцийг сайжруулах

6.2.2.Бүх сумдын газар зохион байгуулалтын болон нутаг дэвсгэрийн төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх

6.2.3.Хот байгуулалтын үйл ажиллагааны хөрөнгө оруулалт, санхүүжилтийг нэмэгдүүлэх зорилгоор гадаад дотоодын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх

6.2.4.Орчин үеийн технологид тулгуурласан барилгын материалын үйлдвэрлэлийг хөгжүүлж, бүтээгдэхүүний чанарыг сайжруулж, нэр төрлийг олшруулах, хүн амын хэрэгцээг хангах

6.2.5.Үйлдвэрлэлийн инженерийн дэд бүтцийн хангамжийг сайжруулах

6.2.6.Дэд бүтцийг хөгжүүлэх хотын доторх авто зам, гэрэлтүүлэг, камержуулалтыг сайжруулах, хүүхдийг зам тээврийн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх зорилгоор сургууль, цэцэрлэг орчмын замын гэрэлтүүлэг, тэмдэг тэмдэглэгээ, хурд сааруулагч хийх ажлыг зохион байгуулах

6.2.7.Шинээр баригдсан барилга байгууламжийн зам талбайг тохижилтын хамт иж бүрнээр гүйцэтгүүлэн ашиглалтад хүлээн авч байх

6.2.8.Ногоон байгууламж, амралт зугаалгын талбайг нэмэгдүүлэх, цэцэрлэгжүүлэлт, мод үржүүлгийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуй нэгж байгууллыг дэмжих

6.2.9.Туннелийн сүлжээ бий болгох бэлтгэлийг хангах

6.2.10.Цахилгаан, дулааны эрчим хүчний түгээх хангах шугам сүлжээний өргөтгөл шинэчлэлийн ажлуудыг хийх

**Зорилт 6.3**: Дэлхийн зах зээлд хамгийн бага зардлаар хүрэх тээвэр, зуучлал, эдийн засгийн логистикийг хөгжүүлэх

**Хэрэгжүүлэх гол үйл ажиллагаа**

6.3.1.Бичигт-Баруун Урт чиглэлийн 272 км авто зам, Хөөт-Бичигт-Чойбалсан чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтыг дэмжин оролцож, тэдгээртэй уялдуулан аялал жуулчлалын гол цэгүүдийг тодорхойлж, авто замын сүлжээнд холбох;

6.3.2.Далайд хүрэх хамгийн дөт зам буюу олон улсын тээвэр, харилцаа холбоо, худалдаа эдийн засгийн том зангилаа болсон Бичигт боомтыг хөгжүүлэх төлөвлөгөөтэй уялдуулан суурьшлын бүс, бусад дэд бүтцийг төлөвлөн хөгжүүлэх;

6.3.3.Аялал жуулчлалын гол цэгүүдийг тодорхойлж, авто замын сүлжээнд холбох ажлыг дэмжих, хамтран ажиллах;

6.3.4.Баруун-Уртын нисэх буудлын үйл ажиллагаа, орон нутгийн нислэгийг сэргээн хөгжүүлэхэд санаачилга гарган, хамтран ажиллах;

6.3.5.Аймгийн нутаг дэвсгэр дээгүүр дайран өнгөрч байгаа улсын чанартай авто замуудад технологид суурилсан төлбөр хураах цэг, хяналтын пост барих болон үйлчилгээний цогцолбор барих, газрын асуудлыг шийдвэрлэх, хувийн хэвшлийн хөрөнгө оруулагчдад дэмжлэг үзүүлэх;

6.3.6.Тээвэр логистикийн сүлжээ, терминал байгуулах, олон улсын нэгдсэн хүн-ачаа тээврийн сүлжээнд холбогдох

6.3.7.Төмөр зам, авто замын үйлчилгээ, арчилгааны менежментийн нэгдсэн бодлогыг хэрэгжүүлэх,

6.3.8.Сумын төвүүдийг хатуу хучилттай авто замаар нэгдсэн сүлжээнд холбох ажлыг эхлүүлэх

6.3.9.Улсын чанартай авто замын дагуу 150-200км тутамд үйлчилгээний цогцолбор байгуулан хөгжүүлэх;

6.3.10.Жижиг нисэх онгоц, нисдэг тэрэгний зах зээлийг хөгжүүлж, гамшгаас хамгаалах, хүнс, хөдөө аж ахуй, эрүүл мэнд, уул уурхай, аялал жуулчлалын салбарт ашиглах

6.3.11.Уул уурхайн бүтээгдэхүүн тээвэрлэлтийн замыг хатуу хучилттай болгож, засвар үйлчилгээний ажлыг тогтмолжуулах

**Зорилт 6.4**: Мэдээлэл, холбооны технологийн хүртээмж, ухаалаг хэрэглээг нэмэгдүүлэх

**Хэрэгжүүлэх гол үйл ажиллагаа**

6.4.1.Аймгийн төвд хүрч байгаа мэдээллийн урсгалын ачааллын судалгааг тогтмол хийж, нэмэгдүүлэх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх;

6.4.2.Мэдээлэл харилцаа холбооны салбарын статистик мэдээллийн сан бүрдүүлэх, аялал жуулчлалын бүс болон шаардлагатай бусад цэгүүдэд сүлжээний өргөтгөл хийх чиглэлээр хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтарч ажиллах, тэдний санал санаачилгыг дэмжих;

6.4.3.Иргэдийн тоон гарын үсгийн чадавхийг нэмэгдүүлэх зорилгоор мэдээлэл сурталчилгааны ажлуудыг идэвхжүүлэх;

6.4.4.Төрийн болон үйлчилгээний байгууллагуудыг төрийн үйлчилгээний нэгдсэн системд холбогдон үйл ажиллагаа явуулахад дэмжлэг үзүүлэх;

6.4.5.Өндөр технологи, мэдээллийн технологийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг бий болгох боломжийн судалгаа хийх;

6.4.6.Төрийн байгууллагуудыг онлайн сүлжээнд холбож, видео хурал хийх боломжийг бүрдүүлж холбогдох зардлыг үе шаттайгаар багасгах арга хэмжээ авах;

6.4.7.Хаягжилтын системийн уялдааг сайжруулж нэгдмэл болгох;

6.4.8.Мэдээллийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр иргэдийн мэдлэг, боловсролыг дээшлүүлж, соёлтой хэрэглээг бий болгох

**Зорилт 6.5**: Орон нутгийн чадавхид тулгуурлан инновацыг нутагшуулан, хөгжүүлэх

**Хэрэгжүүлэх гол үйл ажиллагаа**

6.5.1.Уламжлалт мэдлэг, материаллаг болон материаллаг бус байгалийн нөөцийн чадавхад суурилсан шинжлэх ухаан, технологи, үйлдвэрлэлийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлох, бодлого боловсруулах, хэрэгжүүлэх;

6.5.2.Орон нутагт нэвтрүүлэх хэрэгцээ, шаардлагатай шинжлэх ухаан, технологи, инновацын ололт амжилтыг судлах, дотоодын судалгаа, шинжилгээний ажлыг дэмжих зорилготой “Инновац, технологи дамжуулалтын төв” байгуулан хөгжүүлэх замаар эдийн засгийн салбарын хурдасгуур болох;

6.5.3.Тэмүүлэл, хандлагатай залуучуудыг тодорхой чиглэл, зорилго, даалгавар бүхий тогтвортой суурьших гэрээний хатуу нөхцөлөөр дотоод, гадаадад бэлтгэн эрдэм шинжилгээ, судалгаа хөгжлийн судлаачдын тоог нэмэгдүүлэх бодлого хэрэгжүүлэх

6.5.4.Шинжлэх ухаан, технологийн шинэ шийдэл боловсруулах, үр дүнг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэх эрдэмтэн, мэргэжилтнүүдийг таатай нөхцөлөөр орон нутагт суурьшуулан татах;

6.5.5.Хүнсний бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэхэд чиглэсэн боловсруулалт технологи болон сав, баглаа, боодлыг хөгжүүлэх, тээвэрлэх технологийг нэвтрүүлэх замаар бүтээгдэхүүний экспортын тархалтыг хязгаарыг нэмэгдүүлэх;

6.5.6.Малчны хөдөлмөрийг эдийн засгийн үр ашигтай болгох зорилгоор малчин өрхүүдийн цаг ашиглалтын судалгааг боловсруулж бүтээлч үйлдвэрлэлд цаг зарцуулах боломжуудыг илрүүлж орчин цагийн тогтвортой хөгжлийн шаардлагад нийцсэн амьдралын хэв маяг, аж ахуйн загварыг боловсруулж, хэрэгжүүлэх

6.5.7.Нийт хүн амын өвчнийг эрт оношлох, эмчлэх, урьдчилан сэргийлэхэд чиглэсэн дэвшилтэд арга, техник технологийн ололтыг нэвтрүүлэлтийг дэмжих замаар нийгмийн гадагшаа чиглэсэн шилжилт хөдөлгөөнийг бууруулах;

6.5.8.Бүс нутгийн үйлдвэрлэлд орон нутгийн оролцоог хангах замаар кластерын сүлжээнд нэгдэх, борлуулалтын сувгийг нэмэгдүүлэх

6.5.9.Орон нутгийн хөгжлийн сангуудын үр өгөөжийг нэмэгдүүлэх, хөрөнгө хуваарилалтыг ил тод, оновчтой болгох;

6.5.10.Төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааг нэмэгдүүлж, төрийн байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд орон нутагт үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний худалдан авалтыг нэмэгдүүлэх

**Зорилт 7.1**: Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох бодлого хэрэгжүүлж, ус, бэлчээрийн менежментийг сайжруулж, зүй зохистой ашиглах замаар уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг үр дагавар, эрсдэлийг бууруулах

**Хэрэгжүүлэх гол үйл ажиллагаа**

7.1.1.Ойжуулалтыг эрчимжүүлж, иргэд хувийн хэвшлийн идэвхи санаачилгыг дэмжин ойн сан бүхий газрын хэмжээг нэмэгдүүлэх

7.1.2.Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, экологийн эмзэг байдлыг бууруулах бодлогыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах

7.1.3.Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох жишиг төслүүдийг хэрэгжүүлж сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх, гамшгийн эрсдэл, эмзэг байдлыг бууруулах ажлыг орон нутгийн хэмжээнд тогтмол зохион байгуулах

7.1.4.Уур амьсгалын өөрчлөлтийн эмзэг, өвөрмөц экосистемийг тодорхойлж, CLIWARE системээр мэдээллийн сан бүрдүүлж олон нийтэд мэдээлэх нөхцөлийг бүрдүүлэх, эко системийг хамгаалах төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх

7.1.5.Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдсэн дулаарал, агаарын бохирдол, хөрсний талхагдал, цөлжилт зэрэг асуудлуудтай дорвитой тэмцэх, урт хугацааны хөтөлбөр батлан хэрэгжүүлэх, хянах үнэлэх системийг олон нийтэд аль болох нээлттэй ил тод байлгах, байгаль орчинг нөхөн сэргээхэд зарцуулж байгаа зардлын хэмжээг нэмэгдүүлэх

7.1.6.Эко бүтээгдэхүүн үйлдвэрлэж, үйлчилгээ үзүүлж байгаа иргэд, аж ахуйн нэгжүүдэд эко шошго олгох, шалгаруулах, урамшуулах ажлыг эрчимжүүлэх, үйлдвэрлэл эрхлэгчдэд цэвэр үйлдвэрлэлийн механизмын талаарх сургалтыг эрчимжүүлэх, давтан сургалтууд явуулах

**Зорилт 7.2**: Орон нутгийн гамшгийн нөхцөл байдал, эрсдэлийн үнэлгээг бүх түвшинд хийж, гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлж, иргэний нийгмийн байгууллага, иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх

**Хэрэгжүүлэх гол үйл ажиллагаа**

7.2.1.Гол мөрний болон хур бороо, цас мөсний усыг нэмэгдүүлэх, хуримтлуулах, усан сан, хөв цөөрөм байгуулж усан хангамжийг сайжруулж орчны чийгийг хадгалах

7.2.2.Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааг хэрэгжүүлж, суурин радарын системийг нэвтрүүлэх

7.2.3.Сумдын цаг уурын өртөө харуулуудыг автоматжуулж, техник технологийн шинэчлэлийг хийж гүйцэтгэх

7.2.4.Гамшгаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, хойшлуулшгүй сэргээн босгоход шаардагдах гал унтраах болон аврах ажиллагааны багаж хэрэгслийн хангалт, парк шинэчлэлтийг үе шаттайгаар хийж аливаа гамшигтай тэмцэх хүчин чадлыг нэмэгдүүлэх;

7.2.5.УИХ, Засгийн газраас баталсан гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого, Гамшгаас хамгаалах чадавхийг бэхжүүлэх үндэсний хөтөлбөр, Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөр,

Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааг Монгол Улсад хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги зэрэг бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтийг орон нутгийн түвшинд хангаж ажиллах;

7.2.6.Орон нутгийн гамшгийн нөхцөл байдал, эрсдэлийг үнэлэх, гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг төлөвлөж хэрэгжүүлэхэд зарцуулж байгаа зардлын хэмжээг нэмэгдүүлэх;

7.2.7.Орон нутгийн Онцгой байдлын байгууллага, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн гал түймэр, гамшиг, осолтой тэмцэх техник, багаж хэрэгслийн чадавхийг сайжруулах, энэ чиглэлээр олон улсын төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх;

7.2.8.Гамшгаас хамгаалах сайн дурын хэсэг байгуулах, үйл ажиллагааг дэмжих, техник, багаж хэрэгслээр хангах, үйл ажиллагаа явуулах нөхцөлийг бүрдүүлэх;

7.2.9.Гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд хуулийн этгээд, иргэний нийгмийн байгууллага, иргэд, олон нийтийн оролцоог хангах;

7.2.10.Гамшгийн эрсдэлийг бууруулах зорилгоор даатгалын системийг сайжруулах, иргэдийн мэдлэг хандлагыг нэмэгдүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулах

7.2.11.Аюултай хог хаягдал, химийн хорт бодисыг бүртгэх, тээвэрлэх, хадгалах, устгах үйл ажиллагааг стандартын дагуу гүйцэтгэхэд дэмжлэг үзүүлэх, хяналт тавих тогтолцоог сайжруулах

7.2.12.Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх байнгын ажиллагаатай дэд зөвлөл, гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөлөөс хэрэгжүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх

**Зорилт 8.1**: Нутгийн иргэдэд түшиглэсэн байгалийн нөөцийн менежментийг төлөвшүүлж, менежментийн үр ашигтай байдлыг сайжруулж байгалийн нөөц баялгийг хамгаалах, нөхөн сэргээх, зүй зохистой ашиглах бодлогыг хэрэгжүүлэх

**Хэрэгжүүлэх гол үйл ажиллагаа**

8.1.1.Аймгийн хэмжээнд экологийн чухал ач холбогдол бүхий газруудыг улс болон орон нутгийн тусгай хамгаалалт, тусгай хэрэгцээнд авах, шинжлэх ухааны ач холбогдол бүхий тусгай цэгүүдийн тоог нэмэгдүүлэн хамгаалалтад авах ажлыг эрчимжүүлэх

8.1.2.Байгалийн нөөцийг иргэдийн нөхөрлөл, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжид давуу эрхээр ашиглуулах замаар байгалийн нөөцийг үржүүлэх, боловсруулах, үр ашигтай ашиглах нөхцөлийг дэмжих

8.1.3.Цахилгаан, нарны, хийн, хоргол, үртсэн болон түлээний хэмнэлттэй зуухны ашиглалт, ногоон үйлдвэрлэлийг дэмжих

8.1.4.Усны нөөцийг хамгаалж хомсдолоос сэргийлэх нэгдсэн менежментийг хэрэгжүүлж усан сан, хөв цөөрөм байгуулах, иргэд, нөхөрлөлийн хүчээр булаг шандын эхийг хамгаалах тохижуулах, хариуцуулах ажлыг зохион байгуулах

8.1.5.Бохир усыг цэвэршүүлж, дахин ашиглах (саарал ус) технологийг судалж нэвтрүүлэх замаар ус ашиглалтын үр ашгийг дээшлүүлэх

8.1.6.Байгалийн баялаг ашиглан үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдэд байгаль орчны аудит болон мэргэжлийн байгууллагын мониторинг, байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээг хуулийн хугацаанд тогтмол хийлгэж хэвшүүлэх

8.1.7.Бүс нутаг, салбарын хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөө болон төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлыг үнэлэх, байгаль орчны төлөв байдалд үнэлгээ дүгнэлт өгөх, хүрээлэн буй орчинг хамгаалах чиглэлээр сурталчилгаа явуулах, байгаль орчны аудитын хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах

8.1.8.Байгаль орчныг хамгаалахад шинэ техник технологи нэвтрүүлэх, ногоон үйлдвэрлэл, хэрэглээг дэмжиж нутагшуулах ажлыг зохион байгуулах

8.1.9.Хамгаалалтын захиргаа, сумдын байгаль хамгаалагчдын үйл ажиллагааг дэмжиж, байгаль хамгаалагчдыг бие хамгаалах хэрэгсэл, унаа, багаж төхөөрөмж, хувцас, цасны мотоцикл, завь, нэг загварын ажлын байраар хангах, газар нутгийг нь тэмдэгжүүлэхэд анхаарах

**Зорилт 8.2**: Биологийн олон янз байдлын удмын санг хамгаалах, тархац нутаг, амьдрах орчинг тэтгэх замаар хомсдолоос сэргийлэх

**Хэрэгжүүлэх гол үйл ажиллагаа**

8.2.1.Амьтны нөөцийг хамгаалах, үр өгөөжтэй ашиглах, өсгөн үржүүлэх зорилгоор агнуурын менежментийн төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх

8.2.3.Ховор, нэн ховор амьтан ургамлыг зориудаар өсгөн үржүүлэх, сэргээн нутагшуулах, тарималжуулах, зохистой ашиглалтыг дэмжин ажиллах

8.2.4.Ой, ус, амьтан, ургамал, улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газрын нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлэх, ашиглалт, хамгаалалт, шилжилт хөдөлгөөн, өөрчлөлтийн хэтийн хандлагыг тогтоох, зураглал кадастр зохиох, судалгаа хийх

8.2.5.Ан агнуурын менежмент төлөвлөгөөг хэрэгжүүлэх, ан амьтан, байгалийн ургамлын нөөцийн судалгаа хийж, биологийн төрөл зүйлийн нөөцийг нэмэгдүүлэх

8.2.6.Тухайн жилийн орон нутгийн бэлчээрийн даацын мэдээлэлд тулгуурлан хадлан бэлтгэх үйл ажиллагааг 8-р сарын 25-ноос хойш хэрэгжүүлэх

8.2.7.Нутгийн иргэдэд түшиглэсэн байгаль хамгаалах үйл ажиллагааг дэмжиж, чадавхижуулах ажлыг эрчимжүүлэх, биологийн олон янз байдлыг хамгаалах чиглэлээр орон нутгийн болон бусад төсөл хөтөлбөрийн байгууллагатай хамтран ажиллах

8.2.8.Хөдөө аж ахуйд ашигладаг химийн бодисын зохистой хэрэглээ, түүний хяналт, биологийн олон янз байдалд үзүүлэх шууд болон дам нөлөөний талаар олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх

8.2.9.Ургамал хамгаалах болон ургац нэмэгдүүлэх бодисын зохистой хэрэглээний хяналтын механизмыг бүрдүүлэх

**Зорилт 9.1**:Агаар, ус, хөрсний бохирдол, доройтлын шалтгаан, үр дагаврыг судлан тогтоож, байгальд ээлтэй, үр ашигтай цэвэр технологи нэвтрүүлж, орчны бохирдлыг бууруулах

**Хэрэгжүүлэх гол үйл ажиллагаа**

9.1.1.Байгалийн баялгаас олж байгаа ашиг орлогын тодорхой хувь болон учруулсан хохирлын нөхөн төлбөрийн орлогыг тухайн нөөцийг нөхөн сэргээх, байгаль орчны бохирдол доройтлыг арилгахад зарцуулах

9.1.2.Экосистемийн эрсдэлийн менежментийг нэвтрүүлж, үйлдвэрлэлийн эдэлбэр газрын экологи эдийн засгийн үнэлгээ хийж, экологийн хохирол, нөхөн төлбөрийг тооцоолж, байгаль орчин, нийгэмд учруулж болзошгүй нөлөөлөл, эдийн засгийн үр ашгийг харьцуулсны үндсэнд байгаль орчин, нийгэмд халтай төслөөс татгалзах

9.1.3.Агаарын бохирдлын судалгаа, бохирдуулагч эх үүсвэрийн тооллого хийж, агаарын чанарын бүс тогтоох

9.1.4.Агаар, орчны бохирдлыг бууруулах хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх

9.1.5.Агаар орчны бохирдлын хяналтын цэгийг олшруулах, тоног төхөөрөмжийг сайжруулах, шинэчлэх

9.1.6.Газар хөрсний чанарыг тасралтгүй сайжруулах, хөдөө аж ахуйн уян хатан арга туршлагыг нэвтрүүлэх

9.1.7.Аймгийн хэмжээний цөлжилтийн судалгааг ШУ-ны байгууллагаар хийлгэх, цөлжилтийн атлас зураглалтай болох

9.1.8.Аймаг, сумын хэмжээнд хөрсний доройтол, цөлжилтийн шалтгаан, үр дагаврыг судлан тогтоох, мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлж, цөлжилтөөс сэргийлэх бодлого хэрэгжүүлж ажиллах

9.1.9.Хөрс, ус, агаар, усны болон бусад орчны бохирдлыг бууруулах, төв суурин газруудын ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэх ажлыг иргэд, аж ахуйн нэгж, сайн дурынхантай хамтран зохион байгуулах

9.1.10.Аймаг, сумын төвийн хүн амын хурдацтай өсөлтөөс үүдэж буй гадаргын ус, хөрсний бохирдлын хэмжээг бууруулах арга хэмжээ авах

9.1.11.Аймаг, сум, багийн төвд бичил цэцэрлэг, цэцэрлэгт хүрээлэн байгуулах газрыг газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаж, нөөцөд авах

**Зорилт 9.2**: Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь бууруулах, ангилах, дахин ашиглах, дахин боловсруулах менежментийг хэрэгжүүлж, эдийн засгийн эргэлтэд оруулах, хариуцлагатай хэрэглээг дэмжих

**Хэрэгжүүлэх гол үйл ажиллагаа**

9.2.1.Хог хаягдлын менежментийн үр ашгийн талаар нэгдсэн ойлголтод хүргэх бүх нийтийн мэдлэг мэдээлэл дээшлүүлэх, түгээх ажлыг зохион байгуулах

9.2.2.Хог хаягдлыг бууруулах, ангилан ялгах талаар иргэдийн мэдлэг, ухамсар, дадлыг хэвшүүлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулах

9.2.3.Сумдын хог хаягдлын менежментийг сайжруулах, хатуу, химийн болон аюултай хог хаягдлыг төрөлжүүлэн ангилах, дахин боловсруулах, тээвэрлэх, устгах, булах, технологийн шинэчлэлт хийх ажлуудыг зохион байгуулалтад оруулж, зохистой хэрэглээг амьдралд хэвшил болгох ажлуудыг шат дараатай хэрэгжүүлэх

9.2.4.Үйлдвэрлэлд хаягдалгүй эсвэл хог хаягдал бага үүсгэх, шинэ арга, техник, технологи нэвтрүүлэх санал санаачилгыг дэмжих

9.2.5.Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах, тээвэрлэхэд нийцсэн хогийн савтай болгоход иргэд, аж ахуй нэгж байгууллагуудыг татан оролцуулах

9.2.6.Хог хаягдлыг ангилан ялгах, цуглуулах асуудлыг тусгасан нэгдсэн журам батлуулж мөрдүүлэх

9.2.7.Үйлдвэрүүд дахин ашиглах боломжтой хаягдлыг буцааж худалдан авах тогтолцоог бүрдүүлэх

9.2.8.Баруун-Урт хотын хогийн менежментийг сайжруулж, хог хаягдал ангилан ялгаж боловсруулах үйлдвэр байгуулах ажлыг дэмжих

9.2.9.Цэвэрлэх байгууламжийн одоогийн хүчин чадлыг нэмэгдүүлж, техник технологийг шинэчлэх замаар эргүүлэн ашиглах усны хэмжээг нэмэгдүүлэх

9.2.10.Хог хаягдлын эрүүл ахуйн шаардлага хангасан хогийн цэгийг байгуулах, тохижуулах

**Зорилт 10.1**: Бүх нийтийн эрхзүйн боловсролыг дээшлүүлж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийгмийн дэг журмыг хангах замаар амар тайван амьдрах нөхцөлийг бий болгох

**Хэрэгжүүлэх гол үйл ажиллагаа**

10.1.1.Гэмт хэрэг,зөрчлийн шалтгаант нөхцөлийн судалгааг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх

10.1.2.Хууль сахиулах болон шүүх эрх мэдлийн байгууллагуудын хүний нөөц, ажиллах боломж нөхцөлийг үе шаттайгаар нэмэгдүүлэх, холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж, иргэд, олон нийтийн оролцоог идэвхжүүлэх

10.1.3.Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, илрүүлэх ажилд хамааралтай албан хаагчдыг мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулан, орчин үеийн дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх, цагдаагийн инновацыг хөгжүүлэх замаар гэмт хэргэтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг шинэ шатанд гаргах

10.1.4.Шүүхийн шинжилгээний лабораторитой болох

10.1.5.Эрсдэлд суурилсан төлөвлөлт, удирдлага, хяналтын системийг бий болгож эрсдэлийг бууруулах, саармагжуулах цогц бодлого, хөтөлбөрийг боловсруулж цагдаагийн нэгж бүрд эрсдэлийн удирдлагыг нэвтрүүлэх

10.1.6.Баруун-Урт сумын иргэдийн ундны усны эх үүсвэрийг онц чухал объектын жагсаалтад оруулах асуудлыг Монгол Улсын Засгийн газарт уламжлан Дотоодын цэргийн нэгж байгуулах ажлыг шийдвэрлүүлэх ажлыг зохион байгуулах

10.1.7.Улсын хилийн халдашгүй дархан байдлыг ханган өөрийн аймгийн хилийн хэсгийн өргөст утсан торыг стандартын шаардлагад нийцүүлэх, хил хамгаалалтад орчин үеийн дэвшилтэт тоног төхөөрөмж ашиглах нөхцөл боломжийг судлан хэрэгжүүлэх

10.1.8.Иргэдийн зөрчигдсөн эрхийг нөхөн сэргээх, гэмт хэрэг, зөрчлийг шалган шийдвэрлэх хугацааг богиносгох зорилгоор хууль сахиулах байгууллагын материаллаг баазыг нэмэгдүүлэн, бүх сумдыг камерын хяналтын системд холбох

10.1.9.Орон нутгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах, гомдол саналыг шуурхай шийдвэрлэхэд анхаарч, орон тооны бус салбар зөвлөл, "Хэрэглэгчийн төв, улсын байцаагчдын үйл ажиллагааг уялдуулах, дэмжих

10.1.10.Авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар иргэд олон нийтийг соён гэгээрүүлэх сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах

10.1.11.Нийт иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх аймгийн нэгдсэн тогтолцоо бий болгох

10.1.12.Хууль эрх зүйн анхан шатны зөвлөгөө өгөх, зорилтот бүлэгт өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх хууль зүйн туслалцааны чанар, хүртээмжийг сайжруулах

10.1.13.Хууль зүйн туслалцааны анхан шатны үйлчилгээний бодит хэрэгцээ шаардлагыг тогтоож, шийдвэрлэх шаардлагатай бодлогын шийдлийг тодорхойлох чиглэлээр судалгаа шинжилгээний ажлыг тогтмол хийж, үр дүн, үр нөлөөг үнэлж тооцдог болох

10.1.14.Эрх зүйн хөтчийн тогтолцоо бий болгох, иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх

10.1.15.Бүх нийтийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэхэд үүрэн холбооны аж ахуйн нэгж, хэвлэл мэдээллийн байгууллагын үүрэг хариуцлагыг өндөржүүлж, төрийн бус байгууллага, хувийн хэвшил, хэвлэл мэдээллийн байгууллагын эрх зүйн болон хүний эрхийн мэдээлэл, сурталчилгааны ажилд оролцохыг бүх талаар дэмжих

**Зорилт 10.2**: Нутгийн өөрөө удирдах ёсны болон захиргааны байгууллагаас боловсруулж байгаа бодлого, түүний хэрэгжилтэд салбар хоорондын уялдаа холбоо хамтын ажиллагааг хангаж, хяналт үнэлгээний үр дүнг сайжруулах

**Хэрэгжүүлэх гол үйл ажиллагаа**

10.2.1.Нутгийн өөрөө удирдах ёсны болон захиргааны байгууллагын чадавхид үнэлгээ хийж цаашид төгөлдөржүүлэх арга замыг тодорхойлох

10.2.2.Аймаг, сумдын нутгийн өөрөө удирдах ёсны болон захиргааны байгууллагын бүтэц, орон тоог оновчтой тодорхойлж бүрдүүлэх

10.2.3.Багийн Иргэдийн нийтийн хурлын чадавхийг сайжруулж, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх

10.2.4.Хяналтын оновчтой, үр дүнтэй арга хэлбэрүүдийг туршин, нэвтрүүлэх

10.2.5.Орон нутгийн өмчийн удирдлага, зохион байгуулалт, менежментийг боловсронгуй болгох

10.2.6.Төрийн албаны ялангуяа удирдлагын стратегийн төлөвлөлтийн чадавхийг бэхжүүлэх, үр дүнг оновчтой болгон түүнд хөндлөнгийн иргэний нийгмийн байгууллагаар хяналт шинжилгээ, үнэлгээ хийх зэргээр гүйцэтгэлд үндэслэсэн удирдах чадварыг бэхжүүлэх

**Зорилт 10.3**: Төрийн албаны чадавхи, бодлогын залгамж чанарыг сайжруулж, манлайллыг бэхжүүлж, мэргэшсэн, чадварлаг, тогтвортой төрийн албыг төлөвшүүлж, төрийн үйлчилгээг иргэдэд чанартай, шуурхай, тэгш хүртээмжтэй хүргэх

**Хэрэгжүүлэх гол үйл ажиллагаа**

10.3.1.Төрийн албан хаагч, байгууллагын үйл ажиллагааны чадамж, ур чадвар, гүйцэтгэлийн үр дүнг дээшлүүлж, төрийн үйлчилгээг үр дүнтэй, хөнгөн шуурхай хүргэх

10.3.2.Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг чанд мөрдүүлж, төрийн албанд хууль дээдлэх ухамсар, төлөвшлийг хэвшүүлэх

10.3.3.Төрийн албан хаагчийг бэлтгэх, сургах, давтан сургах, мэргэшүүлэх, нийгмийн баталгааг хангах

10.3.4.Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг сайжруулах

10.3.5.Хууль, хяналтын байгууллагын ажилтнуудын ёс зүйн зөрчил, хууль бус үйлдэлтэй холбоотой иргэдийн өргөдөл гомдлыг хүлээн авч, шалган шийдвэрлэх, хариуцлага хүлээлгэх ажлыг шуурхай зохион байгуулж хэвших

10.3.6.Төсөв санхүү, хөрөнгө оруулалтын төлөвлөлт, худалдан авалтын үйл ажиллагааны ил тод байдлыг нэмэгдүүлэх

10.3.7.Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийг бий болгох, бүх төрлийн цахим үйлчилгээг нэвтрүүлэх

10.3.8.Орон нутгийн бодлого, шийдвэрийн үр дүн, төрийн үйлчилгээнд өгч байгаа иргэдийн үнэлгээг оновчтой тодорхойлох

10.3.9.Аймгийн тогтвортой хөгжил, засаглалын шинэчлэлийн хүрээнд мэргэжлийн болон олон нийтийн, эрдэм шинжилгээний байгууллага, их, дээд сургуулиудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх;

**Зорилт 10.4**: Шийдвэр гаргах үйл явцыг ил, тод шуурхай, хүртээмжтэй болгож, иргэд, олон нийтийн оролцоог идэвхижүүлж, нутгийн удирдлагын түвшинд төр, хувийн хэвшил, эрдэм шинжилгээ, иргэний нийгмийн болон хил залгаа, хамтын ажиллагаатай хотуудын түншлэлийг дэмжин хөгжүүлэх

**Хэрэгжүүлэх гол үйл ажиллагаа**

10.4.1.Зөвлөлдөх санал асуулгыг ашиглах боломж бүрдүүлэх, иргэдийг шийдвэр гаргах явцад татан оролцуулах, үүрэг хариуцлагыг нь ухамсарлуулах,

мэдлэгжүүлэх чиглэлийн сургалт сурталчилгаа, нөлөөллийн ажлуудыг зохион байгуулах

10.4.2.Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллага буюу иргэний нийгмийн байгууллагад шилжүүлэх, иргэний нийгмийн байгууллагуудад чиглэсэн сургалт, нөлөөллийн ажлуудыг зохион байгуулж, чадавхыг сайжруулах

10.4.3.Бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, сургалт сурталчилгаа, нөлөөллийн ажил явуулах чиглэлээр орон нутаг дахь төрийн бус байгууллагын чадавхийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах

10.4.4.Олон нийттэй харилцах албаны үйл ажиллагааг бэхжүүлж, цахим систем нэвтрүүлэх

10.4.5. Олон нийтийн эрх ашгийн хөндсөн төрийн захиргааны байгууллагын шийдвэр гаргах үйл явцад иргэдийн оролцоо, ил тод байдлыг хангах замаар авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, сахилга хариуцлагыг нэмэгдүүлэх;

----------o0o----------

## ДӨРӨВ. СҮХБААТАР АЙМГИЙН ХӨГЖЛИЙН ХЭТИЙН ЗОРИЛТЫН ЗОРИЛТОТ ТҮВШИН, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

| № | Зорилт | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Суурь түвшин | Зорилтот түвшин | | Мэдээллийн эх үүсвэр |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | 2018 | 2024 | 2028 | |
| **ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 1: НИЙГМИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ** | | | | | | | |
| **Зорилго нэг. *Хүн амын амьжиргааны түвшинг дээшлүүлж, амьдралын чанарыг сайжруулах*** | | | | | | | |
| 1.1 | Хүн бүрд нийгмийн суурь чанартай үйлчилгээг хүртээмжтэй хүргэж, амьдралын чанарыг сайжруулах | Хүний хөгжлийн индекс | оноо | 0.685 | 0.751 | 0.793 | ҮСХ |
| 1.2 | | Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдсан хүн амын эзлэх хувь | хувь | 38 (2017) | 35.4 | 34 | ХХҮГ |
| 1.3 | | Хөдөлмөрийн насны эдийн засгийн идэвхитэй хүн амын нийгмийн даатгалд хамрагдалт | хувь | 44.7 | 53.4 | 60 | Засаг даргын тайлан 2017 |
| 1.4 | | Баталгаат ундны усаар хангагдсан хүн амын эзлэх хувь | хувь | 57 (2010) | 80 | 90 | ҮСХ |
| 1.5 | | Сайжруулсан ариун цэврийн байгууламжаар хангагдсан хүн амын эзлэх хувь | хувь | 7.1 (2010) | 20 | 40 | ҮСХ |
| 1.6 | | Дэд бүтцэд холбогдсон орон сууцанд амьдардаг өрхийн эзлэх хувь (аймгийн төв) | хувь | 38.2 (2017) | 57.2 | 70 | Засаг даргын тайлан 2017 |
| 1.7 | | Инженерийн дэд бүтцэд холбогдсон аймгийн төвийн гэр хорооллын өрхийн тоо | тоо | 100 (2017) | 300 | 500 | Засаг даргын тайлан 2017 |
| 1.8 | | Цахилгаан эрчим хүчний найдвартай эх үүсвэрээр хангагдсан сум , суурин газрын өрхийн эзлэх хувь | хувь | 47.9 (2010) | 100 | 100 | ҮСХ |
| 1.9 | | 18 ба түүнээс дээш насны хүн амд аймгийн газраас өмчилж авсан иргэдийн эзлэх хувь | хувь | 24.6 | 29 | 31.9 | ҮСХ |
| 1.10 | Зохистой хөдөлмөрийн талаар ажил олгогч бүрд зөв хандлагыг төлөвшүүлж, хөдөлмөр эрхлэлтийн оновчтой бодлогыг хэрэгжүүлж, жижиг, дунд бизнесийг дэмжих замаар иргэн бүрийг ажилтай, орлоготой болгох | Ядуурлын хамралтын хүрээ | хувь | 30.2 | 17.5 | 12.8 | ҮСХ |
| 1.11 | | Ажилгүйдлийн түвшин | хувь | 8.5 | 7.1 | 5.5 | ҮСХ |
| 1.12 | | Ажиллах хүчний оролцооны түвшин | хувь | 71.8 | 74.4 | 75.8 | ҮСХ |
| 1.13 | | Жини коэффициент | индекс | 0.3 (2017) | 0.29 | 0.28 | ҮСХ |
| 1.14 | | Хуримтлалын индекс | индекс | 13 | 19.3 | 24.1 | ҮСХ |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.15 | Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйлчилгээний бүх сүлжээнд эрүүл, аюулгүй байдлын стандартыг хэвшүүлж, хяналтын тогтолцоог сайжруулж, хүн амыг шим тэжээллэг, баталгаат хүнсээр хүртээмжтэй, тогтвортой хангах | 5 хүртэлх насны тураалтай хүүхдийн эзлэх хувь | хувь | 0.9 (2017) | 0.4 | 0.1 | ЭМГ |
| 1.16 | | Цус багадалттай жирэмсэн эмэгтэйчүүдийн хувь | хувь | 1.2 | 0.9 | 0.7 | Эрүүл мэндийн үзүүлэлт 2008-2018 |
| 1.17 | | Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүнийг орон нутгийн үйлдвэрлэлээр хангах хангамжийн түвшин | | (2017) | | | Засаг даргын тайлан 2017 |
| 1.17.1 | | -Мах, махан бүтээгдэхүүн | хувь | 100 | 100 | 100 | УАБЗ |
| 1.17.2 | | -Сүү, сүүн бүтээгдэхүүн | хувь | 55 | 70 | 85 | |
| 1.17.3 | | -Гурил, гурилан бүтээгдэхүүн | хувь | 15.4 | 28 | 40 | |
| 1.17.4 | | -Төмс | хувь | 20.7 | 50 | 80 | |
| 1.17.5 | | -Хүнсний ногоо | хувь | 7.3 | 33 | 60 | |
| 1.17.6 | | -Жимс жимсгэнэ | хувь | 0 | 10 | 20 | |
| 1.18 | | Үйлдвэрлэлийн аргаар боловсруулсан махны ХАА-д үйлдвэрлэсэн нийт маханд эзлэх хувь | хувь | 9.5 (2017) | 20 | 40 | ХОХБТХ |
| 1.19 | | Үйлдвэрлэлийн аргаар боловсруулсан сүүний ХАА-д үйлдвэрлэсэн нийт сүүнд эзлэх хувь | хувь | 0.02 (2017) | 10 | 20 | ХОХБТХ |
| **Зорилго хоёр.** ***Эрүүл, чийрэг иргэнийг төлөвшүүлж, эрүүл мэндийн чанартай тусламж үйлчилгээний хүртээмжийг дээшлүүлж, хүн амын дундаж наслалтыг уртасгах*** | | | | | | | |
| 2.1 | Нийгмийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, иргэдэд эрүүл амьдралын дадлыг хэвшүүлж, урьдчилан сэргийлэх тогтолцоог бэхжүүлэх замаар хүн амын дундаж наслалтыг уртасгах | Хүн амын дундаж наслалт | тоо | 72.7 | 74.3 | 75.5 | ҮСХ |
| 2.2 | | Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдалтын хувь | хувь | 31.7 | 50.4 | 61.3 | Эрүүл мэндийн үзүүлэлт 2010-2018 |
| 2.3 | Халдварт болон халдварт бус өвчний эрт илрүүлэлт, эрүүл мэндийн оношилгоо, эмчилгээ, хяналт, тандалтын чанар хүртээмжийг сайжруулах замаар нас баралтыг бууруулах | Зүрх судасны өвчлөлийн шалтгаант нас баралтын түвшин (10000 хүн амд ногдох) | продецимиль | 16.6 | 13.6 | 12.9 | Эрүүл мэндийн үзүүлэлт 2008-2018 |
| 2.4 | | Хорт хавдрын шалтгаант нас баралтын түвшин (10000 хүн амд ногдох) | продецимиль | 17.3 | 13.7 | 11.9 | Монгол улсын статистикийн эмхэтгэл 2017 |
| 2.5 | | Вирүст хепатит өвчний тохиолдлын түвшин (100 000 хүн амд ногдох) | просантимиль | 1.3 | 0.4 | 0.2 | Эрүүл мэндийн үзүүлэлт 2008-2018 |
| 2.6 | | Сүрьеэ өвчний тохиолдлын түвшин (10 000 хүн амд ногдох) | просантимиль | 10.5 | 7.3 | 6 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.7 | | Халдварт өвчнөөр өвчлөгчид, жилийн эцэст (10 000 хүн амд ногдох) | просантимиль | 110.9 | 73.5 | 58.1 | |
| 2.8 | Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хүн бүрд хүргэх | Эхийн эндэгдлийн харьцаа (100 000 амьд төрөлтөд ногдох) | просантимиль | 0 | 0 | 0 | ҮСХ |
| 2.9 | | Нялхсын эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох) | промиль | 10.7 | 8 | 6.7 | ҮСХ |
| 2.10 | | 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох) | промиль | 16.1 | 12.4 | 9.3 | ҮСХ |
| 2.11 | | Үр хөндөлтийн харьцаа | промиль | 62 | 39.1 | 30.7 | Эрүүл мэндийн үзүүлэлт 2008-2018 |
| 2.12 | | Жирэмслэхээс сэргийлэх орчин үеийн арга хэрэглэдэг эмэгтэйчүүдийн хувь | хувь | 55.5 | 62.3 | 66.3 | |
| 2.13 | | Заг хүйтэн өвчнөөр өвчлөгчид, жилийн эцэст (10 000 хүн амд ногдох) | продецимиль | 17.3 | 12 | 8.6 | |
| 2.14 | | Тэмбүү өвчнөөр өвчлөгчид, жилийн эцэст (10 000 хүн амд ногдох) | продецимиль | 32.1 | 22.5 | 14.3 | |
| 2.15 | Хүн амын эрэлт хэрэгцээнд нийцсэн, стандартын шаардлага хангасан, хариуцлагатай, хүртээмжтэй, үйлчлүүлэгч төвтэй эмнэлгийн тусламж үйлчилгээний тогтолцоог хөгжүүлэх | Нийт хүн амын эрүүл мэндийн даатгалд хамрагдалт | хувь | 91.8 | 96 | 100 | ЗД-ын үйл ажиллагааны тайлан |
| 2.16 | | 10000 хүн амд ногдох их эмчийн тоо | тоо | 25.3 | 28 | 29.7 | Эрүүл мэндийн үзүүлэлт 2010-2018 |
| 2.17 | | 10000 хүн амд ногдох сувилагчийн тоо | тоо | 35.8 | 43.6 | 49.2 | |
| 2.18 | | Эмнэлгийн тусламж үйлчилгээнд дундаас дээш үнэлгээ өгсөн үйлчлүүлэгчид | хувь | 67 (2016) | 77 | 83 | |
| 2.19 | | Эмч, сувилагчийн харьцаа | тоо | 1.4 | 1.7 | 2 | |
| **Зорилго гурав.** ***Хүн бүрд боловсрол, соёл, шинжлэх ухааны чанартай үйлчилгээг тэгш, хүртээмжтэй хүргэх, насан туршийн боловсролын тогтолцоог хөгжүүлэх*** | | | | | | | |
| 3.1 | Хүүхэд бүрийг стандартын шаардлагад нийцсэн сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын үйлчилгээнд хамруулж, монгол хэл сэтгэлгээний үндсийг эзэмшүүлэх | Сургуулийн өмнөх боловсролын хамрагдалт | хувь | 90.4 | 93 | 96 | Боловсролын хөтөч дэд хөтөлбөрийн тайлан |
| 3.2 | | Суурь боловсролын хамрагдалт | хувь | 98.1 | 100 | 100 | ҮСХ |
| 3.3 | Хөгжлийн тэргүүлэх чиглэл, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлт, шинжлэх | Мэргэжлийн болон техникийн боловсрол олгох сургууль төгсөгчдийн ажлын байраар хангагдсан хувь | хувь | 53 (2017) | 63.2 | 70 | МСҮТ |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.4 | ухаан технологийн дэвшилтэй уялдуулан мэргэжлийн боловсрол, сургалтыг хөгжүүлэх, хувийн хэвшилтэй хамтран төгсөгчдийг ажлын байраар хангах | Мэргэжлийн болон техникийн боловсрол олгох сургуульд суралцагч | тоо | 331 | 409 | 461 | ҮСХ |
| 3.5 | Мэдээллийн технологийн платформд суурилсан насан туршийн боловсролын тогтолцоог бүрдүүлэх | Тогтвортой хөгжлийн боловсролд хамрагдсан иргэдийн эзлэх хувь | хувь | 10.3 (2017) | 60 | 80 | Боловсролын хөтөч дэд хөтөлбөрийн тайлан |
| 3.6 | | Бичиг үсгийн боловсролгүй иргэдийн эзлэх хувь | Хувь | 3.3 (2017) | 0.7 | 0.3 | |
| 3.7 | Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарын хүний нөөцийн тогтвортой бодлогыг хэрэгжүүлж, ажилтны нийгмийн баталгаа хангагдсан хөгжлийг дэмжих тогтолцоог бүрдүүлэх | Инженерийн дэд бүтцэд холбогдсон орон сууцаар хангагдсан ажилчдын эзлэх хувь | хувь | - | 30 | 40 | |
| 3.8 | | Нийт багш нарт магистр болон түүнээс дээш зэрэгтэй багшийн эзлэх хувь | хувь | 10.4 | 18 | 24 | ХОХБТХ |
| 3.9 | Бүх нийтийн биеийн тамираар хичээллэх, амралт чөлөөт цагаа өнгөрүүлэх орчин нөхцөлийг сайжруулж, дэд бүтцийн хүртээмжийг нэмэгдүүлж, үндэсний болон олон улсын спортыг хөгжүүлэх | Нэг хүнд ногдох спорт заалны талбайн хэмжээ | $м^2$ | 0.127 (2017) | 0.19 | 0.24 | Биеийн тамир спортын улсын үзлэг, тооллого 2017, ҮСХ |
| 3.10 | | Нэг хүнд ногдох биеийн тамир, спортын гадаа талбайн хэмжээ | $м^2$ | 1.79 (2017) | 2.15 | 2.65 | |
| 3.11 | Аймгийн брэнд бүхий соёлын биет бус өв, бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх, соён гэгээрүүлэх ажлыг шинэ шатанд гаргах | ДНБ-д соёлын бүтээлч үйлдвэрлэлийн эзлэх хувь | хувь | - | 0.5 | 1 | БСУГ |
| **Зорилго дөрөв.** ***Хүн бүрийн эрхийг хүндэлж, тэдний онцлог хэрэгцээнд нийцүүлэн хөгжих, суралцах, хөдөлмөрлөх таатай орчин нөхцөлийг бүрдүүлэх*** | | | | | | | |
| 4.1 | Гэр бүл, хүүхдэд ээлтэй хөгжил, хамгааллын бодлогыг хэрэгжүүлж, хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлэх замаар хүн амын өсөлт, хөгжлийг дэмжих | Өсвөр насны хүүхдийн урьдчилан сэргийлэх үзлэгийн хувь | Хувь | 45 (2017) | 69 | 85 | Өсвөр үеийнхний эрүүл мэнд дэд хөтөлбөр |
| 4.2 | | Өсвөр насны хүүхдийн шүдний үзлэгийн хувь | Хувь | 47 (2017) | 66.8 | 80 | |
| 4.3 | | 6-19 насны хүүхдийн осол гэмтлийн өвчлөл | Тоо | 98 (2017) | 84.8 | 76 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.4 | | Гэмт хэрэг үйлдсэн хүүхдийн тоо | Тоо | 10 | 5.8 | 3 | ЦГ статистик |
| 4.5 | | Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэргийн тоо | тоо | 42 (2017) | 27 | 17 | ЦГ статистик |
| 4.6 | | Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг | тоо | 11 | 6 | 3 | ЦГ статистик |
| 4.7 | Залуучуудын гэр бүл төлөвлөлтийн талаарх мэдлэгийг дээшлүүлж, гэр бүлийн тогтвортой байдлыг хангах, залуучуудыг түүх, соёл, зан заншил, уламжлалаа мэддэг, эх оронч үзэлтэй, бие даан амьдрах чадвартай, хариуцлагатай иргэн болгон төлөвшүүлэхэд нийгмийн үйлчилгээг чиглүүлж, залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих | 15-24 насны залуучуудын ажилгүйдлийн түвшин | хувь | 20.8 (2015) | 9.2 | 5.8 | ҮСХ |
| 4.8 | | Гэр бүл цуцлалт, 1000 хүн амд ногдох | тоо | 0.9 | 0.6 | 0.5 | ҮСХ |
| 4.9 | Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан дэд бүтцийг сайжруулж, тэдэнд нийгмийн хамгаалал, халамжийн үйлчилгээг жигд тэгш хүргэх, хөгжилд хувь нэмрээ оруулан бие даан амьдрах таатай орчинг бүрдүүлэх | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан дэд бүтцийг бий болгосон байгууллагын тоо | тоо | 5 (2017) | 9 | 12 | ЗД-н тайлан 2017 |
| 4.1 | | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн цэцэрлэг, сургуульд хамрагдалтын хувь | хувь | 60 (2017) | 67 | 72 | ЗД-н тайлан 2017 |
| 4.11 | | "Ахмадын зөвлөх үйлчилгээ" хөтөлбөрт хамрагдсан ахмад настны тоо | тоо | 11 (2017) | 65 | 104 | ЗД-н тайлан 2017 |
| 4.12 | Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцаан дахь жендерийн эрх тэгш байдлыг хангаж, нийгмийн амьдралд оролцох оролцоог дээшлүүлж, шийдвэр гаргах бүх түвшинд эмэгтэйчүүдийн эзлэх хувь хэмжээг нэмэгдүүлэх | ААНБ-ын эмэгтэй, эрэгтэй ажиллагчдын цалингийн ялгаа | индекс | 0.91 | 0.95 | 0.97 | ҮСХ |
| 4.13 | | Эрэгтэй эмэгтэй хүмүүсийн ажиллах хүчний оролцооны түвшний зөрүү | индекс | 6.9 | 5.7 | 4.8 | ҮСХ |
| 4.14 | | Аймгийн ИТХ-д сонгогдсон гишүүдэд эмэгтэйчүүдийн эзлэх хувь | хувь | 15.1 | 20 | 30 | ХОХБТХ |
| 4.15 | | Төрийн захиргааны удирдах албан тушаалтанд эмэгтэйчүүдийн эзлэх хувь | хувь | 40.5 (2017) | 45 | 50 | ХОХБТХ |
| 4.16 | | Жендерийн тэгш бус байдлын индекс | оноо | 0.815 | 0.675 | 0.607 | ҮСХ |



43

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 2: ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ** | | | | | | | |
| **Зорилго тав.** ***Эдийн засгийн өрсөлдөх чадварыг дээшлүүлж, бие даасан байдлыг хангах*** | | | | | | | |
| 5.1 | Эдийн засгийг төрөлжүүлэн хөгжүүлж, түүний өсөлтийг тогтворжуулан улсын төсвөөс хамааралтай байдлыг бууруулах | Төсвийн нийт орлогод улсын төсвөөс олгосон санхүүгийн дэмжлэгийн эзлэх хувь | хувь | 13.7 | 4.3 | 0 | ҮСХ |
| 5.2 | | Төсвийн тэнцэл (ДНБ-д эзлэх хувь) | хувь | -0.1 | 0 | 1 | ҮСХ |
| 5.3 | | Нийт экспортын ДНБ-д эзлэх хувь | хувь | - | 2 | 5 | |
| 5.4 | | Нэг хүнд ногдох ДНБ | мянган төгрөг | 8,088 | 12,630 | 16,938 | ҮСХ |
| 5.5 | | ДНБ, оны үнээр | тэрбум төгрөг | 501.2 | 818 | 1,133 | ҮСХ |
| 5.6 | Бизнес эрхлэх таатай орчин, дэд бүтцийг бүрдүүлж, нэмүү өртгийн сүлжээ бүхий технологи, инновацын ололтод суурилсан эдийн засгийн үр ашигтай орон нутгийн эко бизнес, үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээг хөгжүүлэх | ДНБ-д боловсруулах үйлдвэрлэлийн эзлэх хувь | хувь | 12 | 17.5 | 21.6 | ҮСХ |
| 5.7 | | ДНБ-д үйлчилгээний салбарын эзлэх хувь | хувь | 15.4 | 19.1 | 21.7 | ҮСХ |
| 5.8 | | Үйлдвэрлэлийн аргаар боловсруулсан махны ХАА-д үйлдвэрлэсэн нийт маханд эзлэх хувь | хувь | 9.5 (2017) | 20 | 40 | ХОХБТХ |
| 5.9 | | Үйлдвэрлэлийн аргаар боловсруулсан сүүний ХАА-д үйлдвэрлэсэн нийт сүүнд эзлэх хувь | хувь | 0.02 (2017) | 10 | 20 | ХОХБТХ |
| 5.10 | | Бизнес инкубатор болон бизнесийн хөгжлийг дэмжих төв | тоо | 0 | 2 | 4 | |
| 5.11 | | Бизнесийн зөвлөх үйлчилгээ эрхлэгчдийн тоо | тоо | - | 5 | 8 | |
| 5.12 | | Аймгийн өрсөлдөх чадварын индекс | оноо | 79 | 84 | 90 | Аймгуудын өрсөлдөх чадварын судалгааны тайлан 2018 |
| 5.13 | Унаган байгаль, түүх, соёл, нүүдэлчин ахуйг түшиглэсэн хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд суурилсан эко бизнес, хил орчмын аялал жуулчлалыг эрчимтэй хөгжүүлэх | Нийт жуулчдын тоо | мянган хүн | 23.4 (2017) | 45.7 | 67 | БОАЖГ |
| 5.14 | | Жуулчдын аюулгүй байдлыг хангах зөвлөлтэй сумын тоо | тоо | 0 | 6 | 13 | БОАЖГ |
| 5.15 | | Чадавхжуулах сургалтад хамрагдсан аялал жуулчлалын үйлчилгээний ажилчдын тоо | тоо | 101 (2017) | 151 | 200 | ЗД-н тайлан |
| 5.16 | Технологи, инновацад суурилсан өрсөлдөх чадвартай, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн загвар аймаг болох | Фермерийн аж ахуй | тоо | 50 (2017) | 59 | 65 | ХХААГ |
| 5.17 | | 100 га бэлчээр, хадлангийн талбайд ногдох хонин толгойд шилжүүлсэн малын тоо | Тоо | 88.8 | 77 | 64 | ҮСХ |
| 5.18 | | Бэлчээрийн усан хангамж | хувь | - | 85 | 90 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 5.19 | | Эргэлтийн талбайн нийт хэмжээ (Нийт тариалсан талбай) | мянган га | 7 | 14.9 | 19.7 | ҮСХ |
| 5.20 | | 1 га талбайгаас хураасан ургац | | | | | |
| 5.20.1 | | -Үр тариа | ц | 5.1 | 6 | 9.8 | ҮСХ |
| 5.20.2 | | -Төмс | ц | 92.3 | 104.2 | 115.1 | ҮСХ |
| 5.20.3 | | -Хүнсний ногоо | ц | 83 | 87.7 | 93.7 | ҮСХ |
| 5.20.4 | | -Тэжээлийн ургамал | ц | 59.5 | 84 | 102 | ҮСХ |
| 5.21 | | Бэлтгэсэн гар тэжээл | Тн | 341.7 | 628 | 1094 | ҮСХ |
| 5.22 | | Бэлтгэсэн өвс, хадлан | мян.тн | 15 | 47 | 64 | ҮСХ |
| 5.23 | Байгалийн нөөц, ашигт малтмалын баялагт суурилсан ил тод, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх замаар орон нутгийн хөгжлийг дэмжиж бүсийн эдийн засгийн тулгуур төв болох | Аж үйлдвэрлэлийн салбарт уул уурхайн олборлолтын эзлэх хувь | хувь | 72.6 | 66.7 | 63.6 | ҮСХ |
| 5.24 | | Нөхөн сэргээлт хийсэн талбайн хэмжээ | га | - | 10 | 15 | БОАЖГ |
| **Зорилго зургаа. *“Нэг бүс нэг зам” санаачилгыг дэмжин Ази – Европыг холбосон эдийн засгийн хөгжлийн коридорыг байгуулан, бүс нутгийн интеграцид идэвхитэй оролцох*** | | | | | | | |
| 6.1 | Шинэ технологи, сэргээгдэх эрчим хүчийг нэвтрүүлж хэрэглээг дэмжих, тогтвортой үйлдвэрлэлийг хөгжүүлэх | Сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийн хүчин чадал | мВт | - | 10 | 20 | |
| 6.2 | | Түгээх болон дамжуулах сүлжээний алдагдал | хувь | 10 (2017) | 9.1 | 8.6 | ДБЭХС ХК |
| 6.3 | Хот байгуулалт, инженерийн дэд бүтцийг сайжруулан, иргэдийн эрүүл аюулгүй тохилог орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх | Хог хаягдлын дахин боловсруулалтын хувь | хувь | 0 | 30 | 50 | |
| 6.4 | Дэлхийн зах зээлд хамгийн бага зардлаар хүрэх тээвэр, зуучлал, эдийн засгийн логистикийг хөгжүүлэх | Ачаа эргэлт, авто зам | сая.тн.км | 62.6 | 86.1 | 103.2 | Аймгийн статистикийн эмхэтгэл |
| 6.5 | | Тээсэн ачаа, авто зам | мян.тн | 221.1 | 253.1 | 273.5 | |
| 6.6 | | Хатуу хучилттай автозамын сүлжээнд холбогдсон сумын тоо | тоо | 3 | 5 | 8 | |
| 6.7 | Мэдээлэл, холбооны технологийн хүртээмж, ухаалаг хэрэглээг нэмэгдүүлэх | Аймгийн нийт өрхөд интернэтэд холбогдсон өрхийн эзлэх хувь | хувь | 2 (2017) | 5.9 | 11.2 | ХОХБТХ |
| 6.8 | | 100 хүн амд ногдох үүрэн холбооны хэрэглэгчийн тоо | тоо | 115.8 (2017) | 120 | 125 | ХХЗХ-ны танилцуулга |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 6.9 | Орон нутгийн чадавхид тулгуурлан инновацыг нутагшуулан, хөгжүүлэх | Жилд шинээр авсан болон нутагшуулсан патентын тоо | тоо | - | 5 | 8 | ХОХБТХ |
| 6.10 | | Эрдэм шинжилгээ, хөгжлийн судлаачдын тоо | тоо | - | 91 | 100 | ХОХБТХ |
| 6.11 | | Судалгаа хөгжүүлэлтийн зардлын аймгийн ДНБ-д эзлэх хувь | хувь | 0 | 1.5 | 2 | ХОХБТХ |
| **ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 3: БАЙГАЛЬ ОРЧНЫ ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ** | | | | | | | |
| **Зорилго долоо. *Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг багасгах, цаг агаарын аюулт үзэгдэл, байгалийн гамшигийг даван туулах, тэдгээрт дасан зохицох чадавхийг бэхжүүлэх*** | | | | | | | |
| 7.1 | Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох бодлого хэрэгжүүлж, ус, бэлчээрийн менежментийг сайжруулж, зүй зохистой ашиглах замаар уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг үр дагавар, эрсдэлийг бууруулах | Аймгийн нийт төсөвт уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох арга хэмжээнд зарцуулсан зардлын эзлэх хувь | Хувь | 0.1 (2017) | 0.3 | 0.5 | БОАЖГ |
| 7.2 | Орон нутгийн гамшгийн нөхцөл байдал, эрсдэлийн үнэлгээг бүх түвшинд хийж, гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлж, иргэний нийгмийн байгууллага, иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх | Нэг жилд гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах чиглэлийн сургалтад хамрагдсан иргэдийн тоо | мянган хүн | 3.8 (2017) | 5 | 8 | ОБЕГ |
| 7.3 | | Аймгийн нийт төсөвт гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээнд зарцуулсан зардлын эзлэх хувь | хувь | 0.4 | 0.6 | 1 | ОБЕГ |
| **Зорилго найм. *Амьтан, ургамал, тэдний удмын санг хамгаалах, зүй зохистой ашиглах*** | | | | | | | |
| 8.1 | Нутгийн иргэдэд түшиглэсэн байгалийн нөөцийн менежментийг төлөвшүүлж, менежментийн үр ашигтай байдлыг сайжруулж байгалийн нөөц баялгийг хамгаалах, нөхөн сэргээх, зүй зохистой ашиглах бодлогыг хэрэгжүүлэх | Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн эзлэх хувь | хувь | 35 (2017) | 38 | 40 | ҮСХ |
| 8.2 | | Жилд ойжуулсан талбайн хэмжээ | га | 10 | 13 | 16 | Ойжуулалтын тайлан |
| 8.3 | | Хамгаалж тохижуулсан булаг шандын тоо | Тоо | 11 | 13 | 15 | БОАЖГ |
| 8.4 | | Байгалийн нөөцийг хамгаалж, зохистой ашиглах гэрээтэй нөхөрлөлийн тоо | Тоо | - | 30 | 50 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 8.5 | Биологийн олон янз байдлын удмын санг хамгаалах, тархац нутаг, амьдрах орчинг тэтгэх замаар хомсдолоос сэргийлэх | Нөхөн сэргээсэн бэлчээрийн талбайн хэмжээ | Мянган га | 30 (2017) | 40 | 50 | ХХААГ |
| 8.6 | | Мэрэгч амьтны устгал хийсэн талбайн хэмжээ | Мянган га | 47.2 | 45 | 50 | ХХААГ |
| **Зорилго ес. *Байгаль орчны бохирдол доройтлыг бууруулж, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалах*** | | | | | | | |
| 9.1 | Агаар, ус, хөрсний бохирдол, доройтлын шалтгаан, үр дагаврыг судлан тогтоож, байгальд ээлтэй, үр ашигтай цэвэр технологи нэвтрүүлж, орчны бохирдлыг бууруулах | Хөрсний эвдрэлд орсон талбайн хэмжээ | Га | 236 (2017) | 180 | 120 | БОАЖГ |
| 9.2 | | Бэлчээрийн усан хангамж | хувь | - | 85 | 90 | ҮСХ |
| 9.3 | | Баруун-Урт хотын агаарын чанарын үзүүлэлт (тухайн жилийн хамгийн их утга) | | | | | |
| 9.3.1 | | -Хүхэрлэг хий | Мг/м3 | 0.01 | 0.01 | 0.01 | |
| 9.3.2 | | -Азотын давхар исэл | Мг/м3 | 0.03 | 0.01 | 0.01 | |
| 9.3.3 | | -Тоосжилт (PM10) | Мкг/м3 | - | 0.1 | 0.05 | |
| 9.4 | | Аймгийн төвийн 1 хүнд ногдох ногоон байгууламжийн хэмжээ | $м^2$ | 7.9 (2017) | 12 | 16 | БОАЖГ |
| 9.5 | Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь бууруулах, ангилах, дахин ашиглах, дахин боловсруулах менежментийг хэрэгжүүлж, эдийн засгийн эргэлтэд оруулах, хариуцлагатай хэрэглээг дэмжих | Хог хаягдлын дахин боловсруулалтын хувь | хувь | 0 | 30 | 50 | |
| 9.6 | | Хог ангилан ялгах цэг бүхий сумын тоо | тоо | - | 5 | 13 | |
| 9.7 | | Үйлдвэрлэлийн хаягдал усыг цэвэршүүлж гаргасан саарал усны ашиглалтын хэмжээ | мян м3/жил | 0 | 2 | 4 | |
| **ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 4: ЗАСАГЛАЛЫН ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ** | | | | | | | |
| **Зорилго арав. *Засаглалын бүх шатанд хариуцлага, ил тод байдлыг хангасан, оролцоо бүхий чадварлаг институцийг бүрдүүлэх*** | | | | | | | |
| 10.1 | Бүх нийтийн эрхзүйн боловсролыг дээшлүүлж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийгмийн дэг журмыг хангах замаар амар тайван амьдрах нөхцөлийг бий болгох | 16 ба түүнээс дээш насны 10000 хүн амд ногдох бүртгэгдсэн гэмт хэрэг | тоо | 87 | 69 | 61 | ҮСХ |
| 10.2 | | Гэмт хэрэг үйлдсэн төрийн албан хаагч | тоо | 15 | 0 | 0 | Цагдаагийн Газар, Статистикийн хэлтэс |
| 10.3 | Нутгийн өөрөө удирдах ёсны болон захиргааны байгууллагаас боловсруулж байгаа бодлого, түүний хэрэгжилтэд салбар | Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт | Хувь | - | 88 | 95 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хоорондын уялдаа холбоо хамтын ажиллагааг хангаж, хяналт үнэлгээний үр дүнг сайжруулах | | | | | | |
| 10.4 | Төрийн албаны чадавхи, бодлогын залгамж чанарыг сайжруулж, манлайллыг бэхжүүлж, мэргэшсэн, чадварлаг, тогтвортой төрийн албыг төлөвшүүлж, төрийн үйлчилгээг иргэдэд чанартай, шуурхай, тэгш хүртээмжтэй хүргэх | Авлигын индекс | оноо | 81.8 | 83 | 85 | АТГ |
| 10.5 | | Аймгийн ЗДТГ-ын Шударга байдлын үнэлгээ | оноо | 68.3 | 75 | 79 | АТГ |
| 10.6 | | Шилэн данс хөтлөлтийн хувь | хувь | 98 (2017) | 100 | 100 | Засаг даргын тайлан |
| 10.7 | | Шүүхээр шийдвэрлүүлсэн хөдөлмөрийн маргаан | тоо | 28 | 14 | 10 | ҮСХ |
| 10.8 | | Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийн үнэлгээ | оноо | 3.24 (2017) | 3.6 | 4 | |
| 10.9 | | Төрийн албанаас авсан сүүлийн үйлчилгээндээ сэтгэл хангалуун байгаа хүн амын эзлэх хувь | Хувь | - | 45 | 60 | |
| 10.1 | Шийдвэр гаргах үйл явцыг ил, тод шуурхай, хүртээмжтэй болгож, иргэд, олон нийтийн оролцоог идэвхижүүлж, нутгийн удирдлагын түвшинд төр, хувийн хэвшил, эрдэм шинжилгээ, иргэний нийгмийн болон хил залгаа, хамтын ажиллагаатай хотуудын түншлэлийг дэмжин хөгжүүлэх | Хувийн хэвшил, Төрийн бус байгууллагатай түншилж хэрэгжүүлсэн үр дүнтэй төслийн тоо | тоо | - | 20 | 25 | |
| 10.11 | | Орон нутгийн төсвийн төслийг боловсруулах, батлах үед саналаа албан ёсоор ирүүлсэн иргэний нийгмийн байгууллагын тоо | тоо | - | 15 | 25 | |

Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс